

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
НОМЫН САН**



Шинэ номын мэдээ

2017.12.22

№ 04

Эмхтгэсэн: Ном зүйч С.Найгалмаа


Ном зүйч У.Гэрэлтуяа

Электрон каталоги:

<http://catalog.num.edu.mn>

Гарчиг

1. БАЙГАЛИЙН ШИНЖЛЭХ УХААН	2
2. ТЕХНИКИЙН ШИНЖЛЭХ УХААН	2-3
3. ХИМИЙН ШИНЖЛЭХ УХААН	3
4. УЛС ОРОН СУДЛАЛ, ОРОН НУТАГ СУДЛАЛ	4-5
5. ХӨДӨӨ АЖ АХУЙ	5-6
6. ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ, АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААН	6-7
7. НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН	7
8. ТҮҮХ, ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН	7-12
9. ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН	13-14
10. УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН	14-17
11. ТӨР ЭРХ, ХУУЛЬ ЦААЗЫН ШИНЖЛЭХ УХААН	17-22
12. ЦЭРГИЙН ШИНЖЛЭХ УХААН	22
13. СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, ГЭГЭЭРЭЛ	22-23
14. ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ	24-25
15. ХЭЛ ШИНЖЛЭЛ	25-27
16. АМАН ЗОХИОЛ СУДЛАЛ	27
17. УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ	28-31
18. ГАДААДЫН УРАН ЗОХИОЛ	31-35
19. МОНГОЛЫН УРАН ЗОХИОЛ	35-45
20. УРЛАГ. УРЛАГ СУДЛАЛ	46
21. ШАШИН	47-48
22. ГҮН УХААН	48-49
23. СЭТГЭЛ СУДЛАЛ	49-50
24. ГАДААД ХЭЛ ДЭЭРХ НОМ	50-52

БАЙГАЛИЙН ШИНЖЛЭХ УХААН

Гнэдиг П. ба бус. **Физикийн 200 эгзэгтэй бодлого**: Олон улсын физикийн олимпиадын шигшмэл бодлогууд / Д.Хоньек, К.Райли; Орч. Н.Алтангэрэл, Д.Батхишиг, Ж.Шинэбаяр ба бус.; Ред. М.Ганбат, Д.Улам-Оргих.- УБ.: 2017.- 252х. ISBN 978-99978-0-496-9.

Эл бүтээлд өмнөх жилүүдэд алгасалгүй зохион байгуулагдаж ирсэн Олон улсын физикийн олимпиадад шигшигдсэн физикийн шилдэг бодлогууд төдийгүй мэргэжлийн ном сэтгүүлүүдэд нийтлэгдсэн агуулга гүнзгий, сэдэв өргөн бусад бодлогуудыг түүвэрлэн нэгтгэсэн байна. Англи эхийг орос орчуулгатай нь тулган харьцуулж монгол хэлнээ хөрвүүлсэн ба 200 бодлого бүхэн нөхцөл, тайлбар, бодолт гэсэн бүтэцтэй байгаа нь уншигчийнхаа логик сэтгэлгээг хөгжүүлэх, үзэгдэл процессыг эх-өрнөл-төгсгөл шатлалтай нь багцлан зэрэг ухаарах чадвар эзэмших ач холбогдолтой болжээ.

22.3

Г-46

/БУН унш-7ш, ГНОФ-10ш/

ЭШФ Б-25039-25041

Ургамал судлал: Хээрийн дадлага / Эмхт. Р.Тунгалаг, Ш.Оюунгэрэл; Хян. Н.Сонинхишиг.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2017.- 458х.- ISBN 978-99978-1-019-9.



Хээрийн дадлагын давуу тал нь амьд ургамалтай байгаль дээр танилцаж гадаад шинж төрөх, дотоод бүтэц, физиологийн үйл ажиллагаа, амьдрах орчны хоорондын холбоог судлах ач холбогдолтой билээ. Энэхүү гарын авлагыг биологи, ургамал судлалын чиглэлээр суралцаж байгаа болон мэргэжлийн бус ангийн оюутнууд ашиглах боломжтой юм.

28.5

У-47

/БУН унш-5ш, ГНОФ-7ш/

ЭШФ Б-27096-27098

ТЕХНИКИЙН ШИНЖЛЭХ УХААН

Тэмүүжин Ж. **Нүүрсний үнсний шинж чанар, иж бүрэн боловсруулалт, хэрэглээ** / Ред. Ж.Даваасамбуу, С.Энхтуул.- УБ.: Никель Декель, 2017.- 191х.- ISBN 978-99978-1-171-4.

Энэхүү номонд цахилгаан станцын түүхий эд болох нүүрсний шинж чанар, гарал үүсэл, дэлхий нийтэд үнсийг хэзээнээс ашиглаж эхэлсэн, үнсний цацраг идэвхижил, тэдгээрийн нөлөө зэрэг суурь ойлголтуудыг оруулжээ. Мөн дэлхий нийтээр цахилгаан станцын хаяшдал үнсийг ямар зорилгоор яаж ашиглаж байгааг түүнчлэн Монгол орны төвийн бүсийн голлох цахилгаан станцууд болох Улаанбаатарын 3,4-р дулааны цахилгаан станцын үнсэн сангийн үнс, цахилгаан шүүлтүүрийн үнс, Эрдэнэт, Дарханы цахилгаан станцын үнсэн сангийн үнс, Амгалангийн

дулааны станцын шүүлтүүрийн үнсний шинж чанар, хэрэглээний үзүүлэлтийг тодорхойлжээ.

30.3

Т-89

/БУН унш-7ш, ГНОФ-10ш/

ЭШФ Т-20540-20542

Чарльз Х.Р., Жерри Л.К. **Тоон электроник**: Их, дээд сургуулийн сурах бичиг / Орч. Т.Амартүвшин, Д.Энхзул, Г.Мөнхжаргал; Ред. Д.Эрдэнэчимэг, Ц.Хүрэлбаатар.- 2дахь хэвл.- УБ.: ШУТИС-ийн хэвлэл, 2017.- 470х.- ISBN 978-99962-1-836-1.



Энэхүү ном нь электроникийн болон цахилгааны инженер, компьютерийн ухаан, мэдээллийн технологи, холбооны сургалтын хөтөлбөрүүдийн анхдагч суурь болох юм. Сурах бичиг нь бүлэг тус бүрээр олж авсан суурь онол, ойлголтуудыг бататгах зорилгоор бүлэг тус бүрийн ард мэдлэг шалгах бодлогуудыг хариуны хамт оруулж өгсөнөөрөө онцлог болжээ.

32.85я73

Ч-23

/БУН унш-5ш, ГНОФ-7ш/

ЭШФ Т-20579-20581



Отгонбаяр Б., Буянхшиг Ө. **Хөдөлгөөнт холбоо** / Ерөн. ред. Ч.Гулнар; Ред. З.Буянхшиг.- УБ.: ШУТИС-ийн хэвлэх газар, 2017.- 240х.- ISBN 978-99978-57-17-0.

Уг ном нь мэдээлэл холбооны чиглэлийн мэргэжлийн их, дээд сургуулийн багш, судлаач, оюутан, ашиглалтын байгууллагын инженер техникийн ажилтнуудад хөдөлгөөнт холбооны үндсэн мэдлэг олгоход чиглэгджээ.

Энэхүү номоор дамжуулан хөдөлгөөнт холбооны үндэс, системийн сүлжээ зохион байгуулалт, хөдөлгөөнт холбооны кодлол, радио долгион, CDMA болон GSM суурь систем, 4G LTE технологийн хөгжлийн хандлага, MIMO технологийн хэрэглээний талаар дэлгэрэнгүй тусгасан байна.

32.883я73

О-53

/БУН унш-5, ГНОФ-7ш/

ЭШФ Т-20506-20508

ХИМИЙН ШИНЖЛЭХ УХААН

Химийн бодлого бодох, тооцоо хийх аргачлал / Эмхт. Г.Самдан, Б.Сүхбаатар.- 3дахь хэвл.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2017.- 112х.- ISBN 978-99978-0-632-1.



ХИМИЙН БОДЛОГО
БОДОХ, ТООЦОО ХИЙХ
АРГАЧААЛ



Энэхүү гарын авлага нь ахлах ангийн сурагчид, хими үздэг коллеж, их дээд сургуулийн оюутнууд болон багш нарт зориулагджээ. Мөн хими, биологи, хими технологи ба инженерчлэлийн чиглэлээр их, дээд сургуульд орох

элсэлтийн шалгалт өгөх, химийн бодлого бодох арга эзэмшүүлэхэд чухал үүрэг болохуйц юм.


24.1я7

X-36

/БУН унш-7ш, ГНОФ-5ш/

ЭШФ Б-24956-24957

УЛС ОРОН СУДЛАЛ. ОРОН НУТАГ СУДЛАЛ



Мягмаржав Б. ба бус. **Ертөнцийн долоон гайхамшиг ба Монголчууд: Боть-6** / Л.Баясгалан, Н.Сарангарав; Ред. О.Сүхбаатар.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 224х.- (Хөдөө Аж Ахуйн Их Сургууль. Агроэкологийн сургууль) - ISBN 978-9978-787670.

Энэхүү бүтээл нь 8 бүлэг 29 зүйлтэй бөгөөд үүнд ертөнцийн эртний долоон гайхамшиг ба шинэ долоон гайхамшигийн үүсэл болон түүнтэй Монголчуудын түүх хэрхэн холбогдож байгаа тухай сонирхолтой өгүүлжээ.

Ертөнцийн эртний 7 гайхамшиг ба Монголчууд бүлэгт Египетийн пирамид, Вавилоны дүүжин цэцэрлэг, Египетийн Александри хотын гэрэлт цамхаг ба Монголчууд, Ертөнцийн шинэ 7 гайхамшиг ба Монголчууд бүлэгт Хятадын цагаан хэрэм ба Монголчууд, Петра ба Монголчууд, Колизей ба Монголчууд, Таж Махал ба Монголчууд гэсэн хэсгээс бүрджээ. Мөн байгалийн гайхамшигт тогтоц бүхий Солонгосын Чежү арал, Вьетнамын Халонгийн булан, Индонезийн Комода арал болон Монголын говийн гайхамшиг ба байгалийн үзэсгэлэнт газруудын тухай бичсэн байна.

26.89(1)

M-98

/БУН унш-5ш/

T-20565-202567

Буянжаргал Р. **Дэлхийн нүүрсний гадаад, дотоод зах зээл** / Хян. Г.Цэрэндагва.- УБ.: Адмон принт, 2017.- 240х.- ISBN 978-99978-0-737-3.

Дэлхийн эрдэс баялаг дотроос түлшний эрдэс баялаг чухал байр суурь эзэлдэг бөгөөд түлшний ашигт малтмалын 93%-ийг нүүрс, занар, хүлэр эзэлдэг бол 7%-ийг нефть, хий эзэлдэг байна. Нүүрсний нөөцөөрөө тэргүүлэгч улс орнуудын нүүрсний эрэл хайгуул, олборлолт, хэрэглээ, экспорт, импорт зэргийг он оноор нь харьцуулан хүснэгтлэн оруулж өгсөн нь судлаач уншигчдад харьцуулалт хийхэд амар дөхөм болжээ.


26.343.3

Б-81

/БУН унш-6ш/

ЭШФ Б-24958-24959





Батчулуун Е. **Газарзүйн боловсролын үндэс**: Газарзүйн багш мэргэжлээр суралцагчдад зориулсан сурах бичиг.- УБ.: Мөнхийг үсэг, 2017.- 476х.- ISBN 978-99978-0-790-8.

Энэхүү сурах бичиг нь газарзүйн багш мэргэжлээр суралцагч оюутан, багш нарын төгсөлтийн өмнөх ба дараах сургалтанд зориулагджээ. Газарзүйн боловсролын зорилго, хэрэгцээ, шаардлагыг Монгол орны жишээн дээр тодорхойлж газарзүйн онол, арга зүйн асуудал, газарзүйн соёл ба тогтвортой хөгжил, сурган сэтгэл судлалын үндэс, шинжлэх ухааны үндэс, агуулга арга зүйн хөгжил, үнэлгээ, газарзүйн дидактикийн судалгаа зэрэг 10 бүлэгт багтаан бусад орныхтой харьцуулан жишээгээр тодруулан оруулжээ.

26.8я73

Б-33

/БУН унш-7ш, ГНОФ-10ш/

ЭШФ Т-20503-20505

ХӨДӨӨ АЖ АХУЙ

Төмөржав М., Хүрэлбаатар Н. **Монгол малчны эрдэм ухааны дээж оршвой** / Хян. Т.Туяа, Т.Буянлхам.- УБ.: ТЭПЭ., 2017.- 576х.- ISBN 978-99978-1-252-0.



Дэлхийн соёл, оюуны мэдлэгийн санд Монголчуудын оруулсан дорвитой хувь нэмрийн нэг бол мал аж ахуйг хөтлөх арга, технологи, малтай холбогдсон мэдлэг ухаан юм. Малчин түмний эрдэм ухаан бол өвөг дээдсийн үеэс уламжлагдаж ирсэн арвин баялаг өв сан билээ. Эрдэм мэдлэг бол бусдад өгөх тусам өсч үрждэг баялаг бөгөөд ухаант өвөг дээдсийнхээ дундаршгүй их мэдлэг ухаанаас судалж суралцаж ажил амьдралдаа бүтээлчээр хэрэгжүүлэх нь залгамж үе залуу малчдын хойшлуулшгүй зорилт юм.

45(1)

Т-58

/НУН унш-3ш/

ЭШФ Т-20536-20537



Монгол адууны нэвтэрхий толь: Боть-1.- УБ.: Мөнхийг үсэг, 2016.- 629х.- ISBN 978-99978-4-279-4.

Монголчууд эрт дээр үеэсээ өөрийн гэсэн өвөрмөц “Адууны соёл”-ыг үүсгэн бий болгон баяжуулж ирсэн ард түмэн юм. Энэ үүднээс адуу адуунаас онцгой Монгол адууныхаа “нэвтэрхий толь” хэмээх 2 боть номыг өргөн барьж байна. Нэгдүгээр ботидоо Монгол адууны гарал, угшил, арчилгаа маллагаа, адууны өвчин эмгэг, адууны зүс, хурдан хүлгийн шинж, ашиг шим, адууны тоног хэрэглэлийн нэр, Монгол адууны холбогдолтой ардын аман зохиол, домог хууч, оньсого, дуу, ерөөл магтаал зэргийг өнгөт цомгийн хамт баяжуулан толилуулж байна.

46.11(1)

М-69

ЭШФ Т-20497-20498

Монгол адууны нэвтэрхий толь: Боть-2.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 632х.- ISBN 978-99978-4-279-4.



Монгол адууны нэвтэрхий толийн 1-р ботид Монгол адууны талаарх үндсэн ойлголтыг өгсөн бол энэхүү хоёрдугаар ботидоо Монголын морин уралдааны үүсэл, хөгжил, XIX-р зуунаас уламжлан ирсэн даншиг наадам болон ойн их баяр наадмуудад айргын тавд орсон хурдан хүлгүүдийн товчоон, үе үеийн алдарт уяачдын танилцуулга, Монголын морин спорт, уяачдын холбооны үйл ажиллагааны талаар өнгөт цомгийн хамтаар оруулж өгчээ.

46.11(1)

М-69

ЭШФ Т-20499-20500

ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ, АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААН



Ариунсанаа Б. Эмнэлгийн багаж, хэрэгсэл орчны ариутгал халдваргүйтгэл / Ред. Д.Сэлэнгэ.- УБ.: Эрхэс, 2016.- 228х.

Орчин үед өвчин үүсгэгч нүдэнд үл өртөх бичил биетэн эмнэлгийн аюулгүй ажиллагаа, халдвар хамгааллын доголдолтой үйл ажиллагаанаас болон төрөл бүрийн тоног төхөөрөмж, орон зайгаар дамжин бие махбодийг өвчлүүлсээр байна. Өвчин үүсгэгч эмгэгтөрөгч бичил биетэнд хэрэглэх технологийг боловсруулж, устгаж халдваргүйжүүлэх, ариутгах олон арга зүй, бодисууд, багаж, хэрэгсэл, аппарат, тоног төхөөрөмжийг зохион бүтээсээр байна. Иймд эмнэлгийн дотоод халдвартай тэмцэх ажлыг сайжруулах зорилгоор мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалтанд сурч буй ариутгагчид, оюутан, эмч, эмнэлгийн ажилтануудад лавлагаа болгон энэхүү гарын авлагыг толилуулж байна.

51.2

А-75

/БУН унш-5ш/

ЭШФ Б-24976-24977

Уламжлалт анагаах ухааны онол ба хүний авир араншин / Орч. П.Одгэрэл., Хян. П.Гантуяа.- УБ.: Сэлэнгэпресс, 2017.- 180х.- ISBN 978-99978-0521-8.



Биеийн гурван махбод болох хий, шар, бадгана бол хүний үр хөврөл тогтох, эрүүл орших, өвчлөх ба өтлөх бүрт гол шалтгаан болдог байна. Дорнын уламжлалт анагаах ухаанд хүний бие махбодын төрөлх онцлогийг нарийн тодорхойлж байгаль, цаг агаар, явдал мөр, идээ ундааны нөлөө тэдгээрийн хоорондын хамаарлыг нарийн судалж түүндээ тулгуурлан эмчилж сувилж иржээ. Энэхүү номонд хүний авир араншингийн талаар өрнө дорнын үзэл онол болон түүнийг тодорхойлох тестүүдийг багтаасан байна.

53.59

У-30

/НУН унш-5ш, ГНОФ-5ш/

ЭШФ Б-25015-25017



Фрейд З. **Хүний бэлгийн амьдрал** / Орч. М.Баяртогтох.- УБ.: Битпресс, 2017.- 44х.- ISBN 978-99978-1-257-5.

Уг номын зохиогч З.Фрейд нь эмч нар, мэргэжлийн биш хүмүүст зориулж 35 лекц уншсан байдаг ба тэдгээр лекцийн хоёрыг нь хүний бэлгийн амьдралд зориулсан байдаг бөгөөд бүрэн эхээр нь орчуулан та бүхэнд хүргэж байна. Энэхүү лекцэнд хүүхдийн бэлгийн амьдрал хэрхэн бүрэлдэн тогтдог талаар сонирхолтойгоор тодорхойлсон болно.

57.0

Ф-86

/НУН унш-5ш, ГНОФ-7ш/

ЭШФ Б-27047-27049

НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН

Дарьхүү Р. **Нийгмийн тухай мэдлэг** / Хян. Г.Эрдэнэбаяр, Д.Оюунгэрэл.- УБ.: Тотопресс, 2016.- 378х.- ISBN 978-99962-72-69-1.



Тус гарын авлага нь нийгмийн харилцааны онол, практикийн асуудлаар ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын эзэмшвэл зохих тулгуур ойлголт, үзэл баримтлалыг энгийнээр тайлбарлан, танин мэдүүлэх зорилготой бөгөөд нийгмийн тухай мэдлэг хичээлийн стандарт агуулгын хүрээнд бүлэг бүрийн төгсгөлд өөрийгөө сорих сорилыг оруулсан болно.

60я7

Д-38

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Б-25012-25014

ТҮҮХ, ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН



Дайчин гүрний Дотоод яамны Монгол бичгийн гэрийн данс: 8 боть цуврал / Эрхл. Ш.Чоймаа, Д.Заяабаатар; Ерөн. ред. М.Баярсайхан, Т.Отгонтуул.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- ISBN 978-99978-58-28-3.

“Дайчин гүрний Дотоод яамны Монгол бичгийн гэрийн данс” нь Энх-Амгалангийн 10 дугаар он (1671)-оос Тэнгэрийн тэтгэсний 8 дугаар он (1743)-ы хооронд хамаарах албан баримт, албан захидлыг мөн үед мөнөөхөн “Монгол бичгийн гэр”-ээс эмхлэн дансалж, дэвтэрлэсэн, эдүгээ Бээжин дэх БНХАУ-ын Түүхийн нэгдүгээр архивын хадгаламжид буй дурсгал юм. Энэхүү номонд бичигдсэн түүхэн баримтууд нь тухайн үеийн Монголын түүхэн дэх ээдрээтэй хэрэг явдлуудын учир шалтгааныг бодитой илрүүлэн таних, түүхэн үнэнийг нээн гаргахад чухал ач холбогдолтой бөгөөд анх удаагаа судлаачдад хүрч буй мэдээ олныг агуулжээ.

63.2(1)+63.3(1)52

Д-19

Боть.1: I-III боть.- 576х.

ЭШФ Т-20509-20511

Боть.2: IV-VI боть.- 660х.

ЭШФ Т-20512-20514

Боть.3: VII-IX боть.- 685х.

ЭШФ Т-20515-20517

Боть.4: X-XI боть.- 499х.	ЭШФ Т-20518-20520
Боть.5: XII-XIV боть.- 708х.	ЭШФ Т-20521-20523
Боть.6: XV-XVII боть.-732х.	ЭШФ Т-20524-20526
Боть.7: XVIII-XX боть.- 696х.	ЭШФ Т-20527-20529
Боть.8: XXI-XXII боть.- 463х.	ЭШФ Т-20530-20532

Дайчин гүрний Дотоод яамны Монгол бичгийн гэрийн данс: Дагалга боть / Эрхл. Ш.Чоймаа, Д.Заяабаатар; Ерөн. ред. М.Баярсайхан, Т.Отгонтуул.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 146х.- ISBN 978-99978-58-28-3.



Энэхүү эмхэтгэлээс тухайн цаг үед Монголын хамаатай хэргээр Манжийн хаадын буулгасан зарлиг, Өндөр гэгээн Занабазар, Түшээт хан, Сэцэн хан тэргүүтэй Халхын хан, ноёд, Галдан бошогт, Цэвээнравдан болон Ойрдын ихэс дээдэс хийгээд Далай лам, Банчэн эрдэнэ тэргүүтэн Төвдийн хутагт хувилгаад, Оросын хаант засгаас Чин улсад илгээсэн түүхэн харилцааны бичгүүдтэй танилцах болно.

63.2(1)+63.3(1)52

Д-19

/НУН унш-7ш, ГНОФ-5ш/

ЭШФ Т-20533-20535



Болдбаатар Ж. Монголын тамгатай хутагтууд / Ред. С.Чулуун.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 100х.- ISBN 978-99978-0-282-8.

Энэхүү товхимолын оршил хэсэгт Монгол улс дахь “Тамгатай хутагт судлал”-ын тоймыг хураангуйлан өгүүлж, бүлэг зүйлүүдэд гол гол хутагтын амьдрал, үйл ажиллагааг хураангуйлан дүгнэж оруулсан бйана. Зохиогч номоо судалгаа нийтлэлийн шинжтэй, өргөн олон уншигчдын хутагтуудын талаархи ойлголтыг гүнзгийрүүлэх ач холбогдолтой мөн залуу судлаачдад

арга зүйн болон судалгааны суурь болно гэж үзжээ.

63.3(1)

Б-54

/НУН унш-7ш/

ЭШФ Б-25003-25005

Дашцэрэн Б. Монгол улсын шинэ түүхийн он дарааллын товчоон: 1921-1957 / Эмхт. Д.Эрдэнэбат, Л. Ганбат; Хян. З.Лонжид.- УБ.: Мөнхийн үсэг, 2017.- 294х.- ISBN 978-99978-0-683-3.




Эх орны түүхийг судлахад түүхийн чухал явдлуудын он дарааллыг нэгэн мөр болгон, үнэн зөвөөр журамлах нь түүхийн дэс дарааллыг нарийн чанд тогтооход чухал ач холбогдолтой юм. Энэхүү Монголын түүхийн чухал явдлуудын он дараалсан лавлахад нэгдүгээрт болсон явдлыг он, сар, өдрөөр нь, хоёрдугаарт бүх номыг григорийн тооллоор авах, гуравдугаарт уг явдлуудыг голчлон жинхэнэ тулгуур материалыг баримтлан хийсэн ба уул явдлын утга учрыг чухал дурдах, ашигласан материалын товъёог явдал бүр дээр нь зүүлтээр тавьж өгчээ.

63.3(1)

Д-39

ЭШФ Б-25044



Мягмаржав Б. Гео эдийн засаг-“Монголын нууц товчоон”-д: 16 боть (7) / Ред. М.Халиун.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 376х.- ISBN 978-99978-1-418-0.

Энэхүү бүтээл нь орчин үеийн гео-эдийн засгийг мэдэхийн зэрэгцээ Монголын эзэнт гүрний түүх, үүнээс “Монголын нууц товчоо”-г судлах, сурталчлахад онол, практикийн их ач холбогдолтой юм. Дэлхийн дэд бүтэц ба орчин үеийн гео-эдийн засаг болон “Монголын нууц товчоо”-ны хоорондын уялдаа холбоог гаргасан 13 бүлэг, олон хүснэгт диаграмм, газрын зураг зэргийг гаргаж тавьсанаараа Монголын төдийгүй Монгол туургатны сонирхолыг татах бүтээл болжээ.


63.3(1)

М-98

/НУН унш-5ш/

ЭШФ Т-20562-20564

Саундерс Ж.Ж. Монголын байлдан дагууллын түүх / Орч. Ж.Гэндэндарам; Хян. Д.Баясгалан.- УБ.: Бэмби сан, 2017.- 350х. (Gems of wisdom-19)



XIII зууны үеийн Монголын байлдан дагуулал нь дэлхийг хөмрүүлэн эргүүлж, бөмбөрцгийг Германаас Солонгос хүртэл нэвт сүлбэж, хаант болон эзэнт улс гүрэн бүгдийг сөгдүүлэн дагуулж чичрүүлэн өөрчилсөн билээ. Зэрлэг алан сүйтгэгч, хэрцгий балмад нэгэн гэгддэг Чингис хаан бол их улс төрч, цэргийн их стратегч, цэргийн эрдмийг боловсруулан хөгжүүлсэн зүтгэлтэн, өрнө дорнын соёлыг хооронд нь холбосон гавъяатай хүн гэдэг үзлийг бий болгохыг энэ бүтээлээрээ зорьжээ.

63.3(1)

С-37

ЭШФ Б-26987-26988



Сун лиань. Юань улсын судар: Илтгэл: 106-113-р боть / Орч. Д.Идэр.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 212х.- ISBN 978-99978-1-064-9.

“Юань ши” буюу “Юань улсын судар” нь эртний хятад хэл дээр бичигдсэн XIII-XIV зууны Монголын түүхийн сурвалж бичгийн нэг юм. Энэхүү сурвалж бичиг нь “Уг тэмдэглэл”-47 боть, “Ойллоло”-58 боть, “Илтгэл”-8 боть, “Олон шастир”-96 боть, нийт 210 ботиос бүрдэнэ. Энэ удаагийн хэвлэл нь эдгээрээс “Илтгэл”-8 боть буюу Юань улсын судрын 106-113-р ботийг эртний хятад хэлнээс орчуулж, оршил тайлбарыг бичиж хэвлүүлсэн болно.

63.3(1)43

С-73

/НУН унш-7ш/

Т-20576-20578

Дашдулам Д. **Баруун хязгаараас төрсөн төр, нийгмийн зүтгэлтэн Өлзийтийн Бадрах** / Хян. Л.Чулуунбаатар.- УБ.: Соёмбо принтинг, 2016.- 150х.- ISBN 978-99962-67-81.




Энэ номонд Монголын түүхийн ээдрээт үе болох “баруунтан”, “зүүнтэн”-ий үеийн Монгол улсын төр, нийгмийн зүтгэлтэн алс баруун хязгаараас төрсөн анхны төрийн сайд, бичгийн хүмүүн, МАН-ын зүтгэлтэн Ө.Бадрахын амьдрал, үйл ажиллагааг өгүүлнэ. Тэрээр 29 настайдаа МАН-д гишүүнээр элсэж Улсын анхдугаар хуралд төлөөлөгчөөр сонгогдож улмаар Улсын Бага хурлын гишүүн болсноор нам төрийн ажилд гар бие оролцож эхэлжээ. Улмаар их хэлмэгдүүлэлтийн үед “Хувьсгалын эсэргүү” хэмээн 1937 онд баривчилж, 1941 онд 46-хан насанд нь ЗХУ-д цаазаар авсан байна.

63.3(1)-8

Д-39

/НУН унш-3ш/

ЭШФ Т-20568-20569



Цэгмид С. **Монгол судлалд нэмэрлэсэн эрлийн олз** / Ред. Д.Баттогтох.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2017.- 130х.

Улс үндэстний түүх нь нэг хүн, нэг гэр бүл, нэг үеийнхний түүхээс эхэлдэг болохоор эл номд Монголын нэгэн үеийн оргил болсон эрдэмтэн Ц.Дамдинсүрэн, Ш.Лувсанвандан, Б.Ринчен тэргүүтэн монгол судлалын нэрт эрдэмтэд, гавьяат багш, алдарт бөх, төрийн сайд, сэтгүүлчид гээд нийгмийн олон салбарын гавьяат үйлстнүүдийн тухай эрэн сурвалжилж

бичсэн зурвасхан хөргүүд, сэтгүүлчийн тэмдэглэл, судалгааны өгүүлэл, нийтлэлийг оруулжээ.

63.3(1)-8

Ц-92

/НУН унш-3ш/

Б-27162-27163

Цэнд гүнгийн хөрвүүлсэн Монголын нууц товчоо / Эрхл. Д.Начин; Ред. Ц.Оюунсүрэн.- УБ.: Ти Ди Ар Ди, 2017.- 660х.- ISBN 978-99978-1-679-5.

Бодлогот баатар гүн Цэнд нь ном зохиол уншиж судалдаг, хэд хэдэн хэл эзэмшсэн, бичгийн өндөр соёлтой хүн байсан тул төрийн их албанд зүтгэхийн зэрэгцээ “Монголын нууц товчоо”-ны иж бүрэн 12 дэвтрийг Е Дэхуйн бар хэвлэлээс монгол бичгээр хөрвүүлэн сэргээн буулгах ажлыг хийж 1917 онд дуусгасан байна. Энэхүү ном нь Цэнд гүнгийн хөрвүүлсэн “Монголын нууц товчоо”-ны гар бичмэл бөгөөд уйгаржин монгол бичгээр хэвлэгджээ.

63.3(1)

Ц-95

/НУН унш-5ш/

ЭШФ Т-20557-20558





Симонов К. **Хаа холын Дорнын тэртээд**: Халхын голын тэмдэглэл: Жуковын намтраас / Орч. Ц.Гомбосүрэн.- УБ.: Мөнхийн үсэг, 2014.- 184х.

Халхын голын байлдаан Зөвлөлт-Монгол, Япон-Манж гогийн цэргийн хооронд болсон тулалдаан бөгөөд манай улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг сахин хамгаалахад Зөвлөлтийнхний үзүүлсэн хувь нэмэр үнэлж баршгүй юм. Хуучнаар ЗХУ-ын нэрт зохиолч К.Симонов 1939 онд Халхын голын дайны төгсгөлөөр сурвалжлах ажлаар томилогдон иржээ. Энэ үеэрээ Халхын голын байлдаанд Зөвлөлтийн цэргийг командлан оролцсон алдарт жанжин Жуковтой танилцаж түүний ярьсныг үндэслэн энэхүү дурсамж номоо бичжээ.

63.3(1)62

С-44

/НУН унш-5ш/

ЭШФ Б-25059-25063

Майорова Е. И. **Их Пётрийн хувийн амьдрал** / Орч. Ч.Чойсамба.- УБ.: Мөнхийн үсэг, 2011.- 395х.- ISBN 978-99973-66-70-2.




Оросын түүхэн дэх аугаа удирдагч, шинэчлэгчдийн нэг гэж үздэг Пётр хааны амьдрал, үйл хэргийн талаар өгүүлэх энэхүү номонд түүний 1696 оноос ганцаар хаанчилсан үе, байлдан дагуулал, хайр дурлал, Оросыг Европын их гүрнүүдийн зиндаанд хүлээн зөвшөөрөгдөх хүртэл хүчирхэгжүүлсэн зэргийг уран сайхнаар сонирхолтойгоор бичжээ.

63.3(2)-8

М-14

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Б-27164-27166



Стариков Н. **1917 оны Октябрийн хувьсгалын нууц**: Тусгай ажиллагаа, төрийн эргэлт, хувьсгал / Орч. Д.Болор; Хян. Ч.Солонго.- УБ.: Соёмбо принтинг, 350х.- ISBN 978-99978-52-13-7.

Энэ номонд Дэлхийн I дайнд амжилттай дайтаж байсан Оросын эзэн хаант гүрний нийслэл Петербургт 1917 оны 2-р сарын сүүлчээр гэнэт гарсан ордны төрийн эргэлтийн талаар түүхэн баримтанд тулгуурлан өгүүлжээ. Энэхүү ордны төрийн эргэлтийг хэн эртнээс төлөвлөн гардан зохион байгуулсан тухай мөн төрийн эргэлтийг хэн гардан үйлдэж улс орноо, дайтаж байсан армийг самран бусниулсан тухай түүхэн үйл явдлыг маш сонирхолтой байдлаар цаг хугацааны дэс дарааллаар өгүүлнэ.

63.3(2)

С-66

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Б-25027-25029

Чан Ю., Холлидэй Ж. **Хэний ч мэдэхгүй Мао**: Боть-1 / Орч. Г.Аким, Баабар, Ц.Ганбат ба бус.; Ред. Б.Гэрлээ.- УБ.: НЭПКО., 2017.- 454х.- ISBN 978-99962-66-33-1.




Энэхүү номонд Хятадын их удирдагч Мао Зэдуны бага наснаас эхлээд Хятадын коммунист намын өрсөлдөгчгүй удирдагч болсон хүртэлх түүний амьдрал, үйл хэргийг маш сонирхолтойгоор бичжээ. Тэрээр 1893 оны 12 сарын 26-нд Манж Чин улс, Хунань муж, Шаошаньд төрж Хятадын марксист онолч, цэргийн болон төрийн зүтгэлтэн, Хятадын коммунист хувьсгалын удирдагч, БНХАУ-ын дарга, ХКН-ын даргаар тус тус ажиллаж хэрхэн Маост Хятад дахь цорын ганц саятан болсон талаар өгүүлнэ.

63.3(5Хят)-8

Ч-19

/НУН унш-4ш, ГНОФ-5ш/

ЭШФ Б-25033-25035



Чан Ю., Холлидэй Ж. **Хэний ч мэдэхгүй Мао**: Боть-2 / Орч. Г.Аким, Баабар, Ц.Ганбат ба бус.; Ред. Б.Гэрлээ.- УБ.: НЭПКО., 2017.- 473х.- ISBN 978-99962-66-33-1.

Энэхүү номын 1-р ботид Мао Зэдуны бага нас болон ХКН-ын удирдагч болох хүртлэх үйл явдлыг өгүүлсэн бол 2-р ботид эх газрын Хятадыг өөрийн болгосон Маогийн дараагийн зорилго бол дэлхийд ноёрхох байсан ба тэрээр энэ мөрөөдлөө гүйцэлдүүлэхийн тулд олон сая хүнийг өлсгөлөнгөөр үхүүлсэн нь хүн төрөлхтний түүхэнд ховорхон тохиолдсон гамшиг байсан талаар дурьджээ.

63.3(5Хят)-8

Ч-19

/НУН унш-4ш, ГНОФ-5ш/

ЭШФ Б-25036-25038

Түдэв Л. **Цээрлэлзүй** / Хян. Т.Шүрбум.- УБ.: Интерпресс, 2016.- 95х.- ISBN 978-99973-981-3-0.



Монголчууд олон мянганы турш "цээрлэл зүй" гэдэг ухааны цогцолборыг хэргэлсээр өнөөг хүрчээ. Тэрхүү "Цээрлэл зүй нь ном, сурах бичиг маягаар хэзээ ч хэвлэгдэж байсангүй. Тийм атлаа тэр "сурах бичгээр" монголын эцэг, эх, ахмадууд үр хүүхдээ, залуу үеэ хүмүүжүүлсээр ирсэн баялаг уламжлалтай билээ. Энэхүү номонд үг, өгүүлбэр бүрийг монгол хүн чээжилчихсэн, чээжиндээ тээж явдаг монгол ардын хүмүүжлийн уламжлалт ухааны аман сургамж болох олон төрлийн цээрийн талаар оруулжээ.

63.5(1)

Т-75

/НУН унш-5ш, ГНОФ-4ш/

ЭШФ Б-25024-25026

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН

Скаузэн М. **Эдийн засгийн ухаан эдүгээчлэгдсэн замнал**: Аугаа сэтгэгчдийн амьдрал, үзэл / Орч. Л.Амарсанаа, Баабар; Орч. ред. Ж.Үнэнбат.- 2дахь хэвл.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 632.- ISBN 978-99973-66-72-6.

Марк Скаузэний энэ ном бол Эдийн засгийн ухааны аугаа их сэтгэгчдийг чөлөөт эдийн засгийн талаас нь харуулсан цорын ганц түүхчилсэн бүтээл юм. Эдийн засгийн ухаан нь түгээмэл ойлголт тул янз бүрийн соёл, амьдралын хэв маягт алинд ч таарна. “Эдийн засгийн ухаан эдүгээчлэгдсэн замнал” ном нь "жам ёсны тогтоц" гэсэн Адам Смитийн загварт эдийн засагчид хэрхэн хандаж байсныг харуулсан анхны бүтээл юм. Энэхүү номоор Монголын ард түмэнд эдийн засгийн аугаа сэтгэгчдийн амьдралын намтар цадигийн талаар болон эдийн засгийн эрх чөлөөний ширүүхэн тэмцлийн түүхийг сөхөн үзэх бололцоо олгож байна.

65г

С-46

/НУН унш-4ш, ГНОФ-5ш/

ЭШФ Т-20554-20556

Паркин М. **Микроэкономикс** / Орч. П.Авралт-Од, Д.Бямбасүрэн; Ред. Д.Гансүлд, Д.Мөнхцэцэг.- 8дахь хэвл.- УБ.: Адмон принт, 502х.- ISBN 978-99978-0-203-3.



Энэ ном нь оюутнуудыг эдийн засгийн сэтгэлгээнд сургаж, эдийн засаг хэрхэн ажилладаг, хэрхэн илүү сайн ажилладаг болгож болохыг ойлгоход туслах бөгөөд динамик харьцангуй тавуу тал, тоглоомын онол, эзэн төлөөллийн бэрхшээл, үйлдвэрлэгчийн орчин үеийн онол, нийтийн сонголтын онол зэргийг энгийн хэллэг, нийтлэг ойлголт, аргачлал ашиглан тайлбарлажээ.

65.012.1

П-18

/НУН унш-7ш, ГНОФ-10ш/

ЭШФ Т-20559-20561



Ганбаатар Д. ба бус. **Менежмент**: Сурах бичиг / Я.Шуурав, Д.Сэржамц.- УБ.: Амар пресс, 2017.- 496х.- ISBN 978-99978-1-266-1.

Энэхүү сурах бичиг нь системлэг, цогц хандах зарчмыг баримталж хэсэг бүр нь эхлэл (пролог), бүлгүүдээс, бүлэг нь товч агуулга, сургалтын зорилго, бүлгийн агуулгатай холбоотой менежментийн асуудал, бүлэг, зүйлийн үндсэн агуулга (текст), давтах асуултууд, уншигч өөрийнхөө мэдлэг, хандлага, байр сууриа тодорхойлох сорил (тест), интернетээр аялахуй (нэмж үзэх материал), ном зүй гэсэн бүтэцтэй байгаа нь багш, оюутан, магистр, докторын зэрэг горилогчид, бие даан менежментэд суралцагч нарт мэдлэг мэдлэгээ дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

65.290-2я73

Г-21

/НУН унш-7ш/

ЭШФ Т-20543-20545

Алтанцоож С. **Зочлох үйлчилгээний чанарын удирдлага** / Хян. С.Амаржаргал.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2017.- 277х.- ISBN 978-99978-1-366-4.



Монгол орны зочлох үйлчилгээний салбар өргөжин тэлж шинэ өнгө төрхийг олж олон улсад үйл ажиллагаатай болон гадаад дотоодын жуулчдын тоо нэмэгдэх хэрээр үйлчилгээний чанарт тавигдах шаардлага, хүлээлт улам бүр өсөж байна. Энэ ном нь чанарын удирдлагын ISO 9000 олон улсын стандартын үүсэл, чанарын удирдлагыг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэрэгсэл, аргачлал, үйлчилгээний чанарын онолын гол загварууд мөн сүүлийн үед трэнд болоод байгаа BIG DATA-гийн талаар дэлгэрэнгүй оруулснаараа шинэлэг болжээ.

65.432

А-48

/НУН унш-3ш/

ЭШФ Т-20490-20491



Лхамцэдэн Б. **Монгол улсын зочид буудлын үйлчилгээний чанарыг үнэлэх нь** / Ред. М.Билэгсайхан.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2017.- 159х.- ISBN 978-99978-0-869-1.



Үйлчилгээний байгууллага нь юуны өмнө өөрийн үйлчлүүлэгчдийг тодорхойлсны дараа тэд тухайн үйлчилгээнээс ямар чанар хүсэж байна, тэдгээрийг ямар хэмжүүрээр үнэлж байгааг тодорхойлох нь чухал байдаг. Энэхүү бүтээл нь Монгол улсын зочид буудлын үйлчилгээний талаарх бодлого боловсруулагчид, зочид буудлын удирдлагууд, байгууллагын чанарын удирдлагын мэргэжилтнүүд үйлчилгээнийхээ чанарт үнэлгээ дүгнэлт өгөх, оновчтой шийдвэр гаргах, цаашдын стратеги төлөвлөлтөнд мэдээлэл болгох мөн их дээд сургуулийн оюутан, судлаачдад нэн тустай юм.

65.432

Л-87

/НУН унш-3ш/

ЭШФ Б-27078-27079

УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН

Россаби М. **Орчин үеийн Монгол** / Англи хэлнээс орч. Ж.Гэндэндарам; Хян. Г.Чулуунбаатар.- УБ.: Бэмби сан, 2017.- 448х.- (Gems of wisdom-20)




Энэхүү бүтээлийн бусад номуудаас ялгарах гол давуу тал, онцлог нь Монголын “Ардчиллын үед” шилжин орсоны эхний 15 жилийн алдаа, дутагдал, өвөрмөц байдлыг гаднын хүний хувьд соргоогоор олж харж, түүнийгээ элдэв давс хачиргүйгээр энгийн ойлгомжтой бичсэн байна.

66.3(1)

Р-76

ЭШФ Б-26989-26990



Цэвэгжавын Пунцагноров: Дурсамж / Эмхт. П.Нарангуа, П.Цолмон, Ц.Эрдэм.- УБ.: Адмон принт, 2014.- 322х.- ISBN 978-99973-0-330-1.

Академич Ц.Пунцагноров нь эх орондоо шинжлэх ухааныг хөгжүүлэх үйлсэд бие сэтгэл, оюун ухаанаа харамгүй зориулж, Монголын ШУА-ыг үндэслэн байгуулалцсан гавьяатан, XX зууны Монголын төр, нийгмийн зүтгэлтэн, нэрт түүхч хүн байсан юм. Академич Ц.Пунцагноровын үр хүүхдүүд нь эцэг эх, өвөг дээдсийнхээ талаарх дурдатгал, дурсамж болон аавынх нь тухай дурьдсан ном товхимол, нийтлэл, дурсамж, захидал зэргээс нь эмхэтгэн 90 насных нь ойгоор "Цэвэгжавын Пунцагноров" хэмээх энэхүү номыг бүтээн өргөн барьж байна.


66.3(1)-8

Ц-92

/НУН унш-3ш/

ЭШФ Б-27083-27084

Вүүд С.Гордон. **Бэнжамин Франклин** / Орч. Т.Ариунсанаа.- УБ.: Мөнхийн үсэг, 2017.- 312х.- ISBN 978-99978-51-04-8.



Америкийн түүхэнд, америкчуудын хувьд сэтгэлгээний бэлгэдлийн чанараараа ямар ч хүн Франклиныг даван гарч чадахгүй юм. Түүний номлолууд эгэл хүмүүсийн өдөр тутмын амьдрал руу нэвчин ордог бөгөөд юуг дагавал сарны гэрэл, юуг дагавал могойн хорлол руу хөтөлдгийг заасан. Чухам энэ нь л түүнийг ардчилсан баатар болгожээ. Энэхүү номонд өөрийнхөө гараар амжилтаа цогцлуулсан түүний амьдрал үнэндээ Америк маягийн амжилтын сонгодог түүх бөгөөд удам судар муутай эгэл хүн эд баялагт хүрэн, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэр алдартай хүн болсныг харуулдаг ажээ.

66.3(7АНУ)8

В-88

/НУН унш-4ш, ГНОФ-5ш/

ЭШФ Б-24997-24999



Моррис М. **Хүмүүн та юу мэдэж байх (мэдэхгүй байх) ёстой вэ!** / Орч. Д.Моононцагаан; Ред. Д.Түмэндэмбэрэл.- УБ.: 2014.- 360х.- ISBN 978-99973-44-55-7.

Михаэль Моррис энэхүү номоороо банк, санхүүгийн тогтолцоо хэрхэн яаж ажилладаг, инфляц хэрхэн яаж, юунаас үүдэж бий болдог, түүнээс хэрхэн сэргийлж зайлсхийх талаар ер бусын энгийн агаад ойлгомжтой байдлаар тайлбарлажээ. Зохиогч Ротшильдынхон болон Рокфеллерийнхний гэр бүлийн пүүс компаниудын өөр хоорондоо хэлхэлдэж сүлжилдсэн байдал хийгээд дэлхийн мөнгө бий болгоход чиглэсэн Олон улсын мөнгөний сангийн үзэл баримтлалыг урьд өмнө огт үзэгдэж харагдаагүй байдлаар баримт, нотолгоотой илчлэн харуулжээ. Гэхдээ тэрээр эдийн засгийн болон нийгмийн салбарт явал зохилтой, юу хийх талаар зарим сонголт болон арга замыг толилуулж байна.

66.4(0)

М-72

ЭШФ Б-27172-27174

Моррис М. **Хүмүүн та юу мэдэж байх (мэдэхгүй байх) ёстой вэ!-2:** Террор, хувьсгал, дайн.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 310х.- ISBN 978-99978-1-466-1.




“Хүмүүн та юу мэдэж байх (мэдэхгүй байх) ёстой вэ!” хэмээн эхний номонд эдийн засаг, санхүүгийн асуудлыг голлон авч үзсэн бол энэхүү хоёрдугаар ботид нэн түрүүнд дэлхийн шинэ дэг журмын улс төр, цэргийн аспект, түүнчлэн манай нийгэм, манай боловсролын тогтолцоонд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хийгээд үзэл суртлын талаас үзүүлж буй нөлөөний тухай асуудлуудыг хөнджээ.

66.4(0)

М-72

/НУН унш-2ш/

ЭШФ Т-20573-20575



Орос-Хятадын гэрээ хэлэлцээрүүдийн эмхэтгэл: 1689-1949 он / Орч. М.Батчимэг.-2дахь хэвл.- УБ.: Ауруг, 2017.- 278х.- ISBN 978-99978-806-2-8.

Орос-Хятадын хоорондын харилцаа нь Монгол улсын төдийгүй бүс нутаг, дэлхий нийтийн аюулгүй байдалд шууд нөлөө үзүүлсээр ирсэн бөгөөд цаашид ч манай улсын гадаад орчныг тодорхойлох үндсэн хүчин зүйл хэвээр байх нь тодорхой бөгөөд Орос-Хятадын харилцааны хэтийн төлөвийг судлахад өнгөрснийг эргэн харах нь нэн чухал учир Орос-Хятадын хооронд 1689-1949 онд байгуулагдсан 63 гэрээ хэлэлцээрийг орчуулан эмхэтгэсэн энэ ном нь түүхч, судлаачдад нэн хэрэгцээтэй бүтээл болжээ.

66.4(2)

О-46

/НУН унш-4ш, ГНОФ-3ш, ОУХНУС-10ш/

Б-27080-27082

Санжмятав Б. **Дипломат болон бизнесийн олон улсын хэлэлцээ:** Онол, технологи, үйл явц, хэлэлцээ хийх үндэстний сэтгэлгээний онцлог, ёслол.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2017.- 214х.- ISBN 978-99978-1-727-3.




Уг номонд олон улсын хэлэлцээний тухай үндсэн ойлголт, технологи, олон улсын хэлэлцээ болон улс төр, эдийн засгийн дипломат ажиллагаа, бизнес хэлэлцээ, олон улсын хэлэлцээ хийх үндэстний онцлогууд, ёслолын ажиллагааны талаар зохиолч маань дипломат албанд 30 жил зүтгэсэн туршлагадаа үндэслэн бичжээ.

66.4

С-31

/ОУХНУС-10ш/



Хайсандай Л. **Монгол улс ба НҮБ: Хамтын ажиллагааны замнал, үр өгөөж** / Ред. Х.Мандухай.- УБ.: Удам соёл, 2016.- 187х. (Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи. Олон Улсын Харилцааны Хүрээлэн).- ISBN 978-99978-0-769-4.

НҮБ-ийн үүсэл, үүрэг зорилго, бүтэц бүрэлдэхүүн болон БНМАУ-ын НҮБ-д элсэн орсон төвөгтэй замнал, Их гүрнүүдийн бодлого, хандлага ба НҮБ-ийн олон улсын хамтын нийгэмлэг дэх Монгол улсын оролцоо мөн НҮБ-ээс Монголд үзүүлж буй тусламж, үр өгөөжийн талаар судалгаан дээр үндэслэн өгүүлжээ.

66.4(1)

X-16

/НУН унш-4ш, ГНОФ-3ш, ОУХНУС-10ш/

Б-27091-27093

ТӨР ЭРХ, ХУУЛЬ ЦААЗЫН ШИНЖЛЭХ УХААН

Судалгааны тайлангийн эмхтгэл-I (2003-2009он) / Эмхт. Д.Мэнджаргал.- УБ.: 2012.- ХЗҮХ хэвлэх үйлдвэр, 800х.- ISBN 978-99962-1-470-7.



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний Иргэн, эдийн засгийн эрх зүй, Захиргаа, хүмүүнлэгийн эрх зүй, Эрүүгийн эрх зүй, криминологи, Олон улсын эрх зүйн секторууд нь тодорхой салбар эрх зүйн чиглэлээр төлөвлөгөөт болон захиалгат эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг хийдэг байна. Энэхүү эмхэтгэлд тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний секторуудын 2003-2009 онд хийсэн эрдэм шинжилгээний судалгааны ажлуудыг эмхтгэн гаргаж байгаа бөгөөд энэ нь эрх зүйн шинжлэх ухааныг шимтэн судалдаг уншигчдын хүртээл болохоос гадна цаашид гүнзгийрүүлэн судлах судлаач, багш, оюутнуудад гарын авлага болохоор бүтээл болжээ.

72+67

C-70

ХЗС 20348



Судалгааны тайлангийн эмхтгэл-II (2010-2011он) / Эмхт. Х.Наранцацрал; Хян. Б.Амарсанаа.- УБ.: 2012.- ХЗҮХ хэвлэх үйлдвэр, 896х.- ISBN 978-99962-57-36-0.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний Иргэн, эдийн засгийн эрх зүй, Захиргаа, хүмүүнлэгийн эрх зүй, Эрүүгийн эрх зүй, криминологи, Олон улсын эрх зүйн секторууд нь тодорхой салбар эрх зүйн чиглэлээр төлөвлөгөөт болон захиалгат эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг хийдэг байна. Энэхүү эмхэтгэлд тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний

секторуудын 2010, 2011 онуудад хийсэн эрдэм шинжилгээний судалгааны ажлуудыг эмхтгэн гаргаж байгаа бөгөөд энэ нь эрх зүйн шинжлэх ухааныг шимтэн судалдаг уншигчдын хүртээл болохоос гадна цаашид гүнзгийрүүлэн судлах судлаач, багш, оюутнуудад гарын авлага болохоор бүтээл болжээ.

72+67

C-70

ХЗС 20349

Судалгааны тайлангийн эмхтгэл-III (2012-2013он) / Эмхт. Б.Гончигсумлаа; Хян. И.Идэш.- УБ.: 2014.- ХЗҮХ хэвлэх үйлдвэр, 634х.- ISBN 978-99962-57-52-0.



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний Иргэн, эдийн засгийн эрх зүй, Захиргаа, хүмүүнлэгийн эрх зүй, Эрүүгийн эрх зүй, криминологи, Олон улсын эрх зүйн секторууд нь тодорхой салбар эрх зүйн чиглэлээр төлөвлөгөөт болон захиалгат эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг хийдэг байна. Тус хүрээлэнгийн 2003-2011 онуудад хийж гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, судалгааны тайлангийн эмхтгэлийн I, II боть нь хуульч, эрх зүйч, их дээд сургуулийн багш, судлаачид, оюутнууд болон хууль сахиулах байгууллагын албан хаагчдын талархлыг хүлээж, судалгааны томоохон эх сурвалж болсон байна. Хууль зүйн судалгааны төвийн судлаачдын 2012-2013 онд хийж гүйцэтгэсэн бодлогын болон бусад судалгааг энэхүү судалгааны ажлын тайлангийн эмхтгэлээр хэвлэн гаргаж байна.

72+67

C-70

ХЗС 20350



“Үндэстэн хуульт ёс ба ерөнхийлөгчийн бүрэн эрх” (Олон улсын онол-практикийн бага хурал) / Эрхл. Ч.Өнөрбаяр, Х.Наранцацрал.- УБ.: ЗГ-ын хэвлэх, 2015.- 140х.



Монгол Улсад Ерөнхийлөгчийн институт байгуулагдсаны 25 жилийн ойн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сантай хамтран “Үндэстэн хуульт ёс ба ерөнхийлөгчийн бүрэн эрх” олон улсын онол-практикийн бага хурлыг 2015 оны 9-р сарын 23-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан билээ. Уг хурлаар эрдэмтэн судлаач, төрийн байгууллагын төлөөллүүд Ерөнхийлөгчийн эрх зүйн байдлыг боловсронгуй болгох асуудал, шүүх эрх мэдэл дэх төрийн тэргүүний бүрэн эрх, Ерөнхийлөгч ба Үндсэн хуулийн цэц хоорондын харилцаа, Ерөнхийлөгчийн хууль тогтоомжид тавих хориг зэрэг асуудлаар илтгэл хэлэлцүүлж, санал солилцсоныг энэхүү номонд эмхэтгэсэн байна.

67.400.6

Y-86

ЭШФ Б-25064-25067

Эдийн засгийн гэмт хэрэг: Гарын авлага / Хян. Т.Алтангэрэл.- УБ.: 2017.- 442х.- ISBN 978-99978-1-683-2.



Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүхийн сургалтын хөтөлбөрийн дагуу шүүгчдийн сургалтын эрэлт хэрэгцээнд тулгуурлан жил бүр шинэ агуулга бүхийн сургалтын хөтөлбөрийг баталж, сургагч багшийн сургалтыг зохион байгуулж, сургалтын гарын авлагыг эмхэтгэн гаргадаг билээ. Энэхүү гарын авлагад эдийн засгийн гэмт хэрэг ба Монгол улсын эрх зүйн зохицуулалт, татварын эрх зүй, татвар төлөхөөс зайлсхийх, хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага, шүүхийн эдийн засгийн шинжилгээ гэсэн үндсэн сэдвүүдийг тусгасан байна.

67.402

Э-19

XЗС 20295-20300



Буянхишиг Б. Гэрээ байгуулах арга техник / Д.Янжинхорлоо, Н.Баасанжав.- 2дахь хэвл.- УБ.: Соёмбопринтинг, 2017.- 216х.- ISBN 978-99973-371-39.

Бизнесийн харилцаанд түгээмэл хэрэглэгдэх Худалдах, худалдан авах гэрээ, лизингийн гэрээ, эвлэрлийн гэрээ, барилгын ажил гүйцэтгэх гэрээ, зөвхөн мэргэшсэн хүрээнд хэрэглэх Франчайзын гэрээ болон гэрээ байгуулах арга тактикийг хөндсөн энэ ном эрх зүйн зөвлөгөө өгөх, гэрээний төсөл боловсруулах, хууль зүйн туслалцаа үзүүлэх, гэрээг гэрчлэх, баталгаажуулах чиг үүргийг хэрэгжүүлэхээр зорьж буй оюутан суралцагсад болон хэн бүхэнд зориулагджээ.

67.404

Б-81

/НУН унш-4ш, ГНОФ-3, ХЗС-10ш/

T-20636-20638

Буянхишиг Б. Хувийн эрх зүй: Онол-арга зүй, эдийн засгийн анализ, харьцуулсан судлал. Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхтгэл. Түүвэр эмхтгэл-1. / Ред. Х.Сэлэнгэ.- УБ.: Соёмбо принтинг, 2017.-180х.- ISBN 978-99978-091-48.



Зохиолч нь Монголын эрх зүйн шинжлэх ухаанд урьд нь судлагдаж байгаагүй, эрх зүйн тогтолцоонд эдийн засгийн анализ хийх онол арга зүйн асуудлыг анх удаа хөндөн судалж, хувийн эрх зүй дэх эдийн засгийн эрх зүйн асуудлаар бичсэн хэд хэдэн судалгааны өгүүлэлээ энэ номондоо багтаажээ.

67.404

Б-81

/НУН унш-4ш, ГНОФ-3ш, ХЗС-10ш/

T-20639-20641



Буянхишиг Б. **Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх явцад эрх зүйн дүгнэлт бэлтгэх**: Хувийн эрх зүй / Ред. З.Сүхбаатар. - УБ.: Соёмбо принтинг, 2017.- 180х.- ISBN 978-99978-0-915-5.

Онол арга зүйн энэ бүтээл нь хууль зүйн салбарт суралцаж, ажиллаж байгаа хүмүүст эрх зүйн тохиолдолд үнэлэлт, дүгнэлт өгөх, тэр дундаа хувийн эрх зүйн салбарын эрх зүйн тохиолдлыг шийдвэрлэхэд Хуулийн зөвлөгч, Өмгөөлөгчийн байр сууринаас хандах ур чадвар, дадал, арга зүйг эзэмшихэд хөтөч болохуйц гарын авлага болно.

67.404

Б-81

/НУН унш-3ш, ХЗС-10ш/

Т-20634-20635

Янжинхорлоо Д. **Иргэний эрх зүйн үндсэн асуудлууд**: Барьцааны эрх зүй / Ред. Т.Мөнхжаргал.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 198х.- ISBN 978-99978-1-627-6.

Энэхүү бүтээлд хууль зүйн сургуулийн оюутнууд болон өөр салбараар суралцагчидад уншиж ойлгоход хялбар байлгах үүднээс хувийн эрх зүйн үндэс болсон иргэний эрх зүйн суурь ойлголтуудыг багтаасан байна. Иргэний эрх зүйн үндсэн асуудлууд, үүргийн эрх зүйн үндэс, барьцааны эрх зүй гэсэн гурван хэсэгтэй.

67.404

Я-61

ХЗС 20303-20332



Нарангэрэл С., Тэмүүлэн Н. **Зохлогчийн эрхийн тулгуур асуудал**. - УБ.: Мөнхийн үсэг, 2008.- 278х.- ISBN 978-99929-1468-7.

Энэхүү бүтээл нь олон улсын гэрээ болон зохиогчийн эрхийн холбогдох хууль тогтоомжид тулгуурлан зохиогчийн эрх зүйн институтын эрх зүйн мөн чанарыг тодорхойлж, зохиогчийн эрх зүйн субъект ба объектын эрх зүйн байдал, тэдгээрийн тогтолцооны хийдэл ба зөрчилдөөнийг олон талаас нь дэлгэрэнгүй тусгасан болно. Их дээд сургуулийн оюутан, магистрант, докторант, багш, эрдэм шинжилгээний ажилтан, хууль зүйн байгууллагын ажилтан, зохиогчийн эрхийн асуудлыг сонирхогч хэн бүхэнд зориулсан байна.

67.404.3

Н-29

ХЗС 20301-20302

Дугармаа А. **Гэр бүлийн эрх зүй** / Хян. Ж.Энхчулуун.- УБ.: Адмон принт, 324х.- ISBN 978-99973-3-908-9.



Энэхүү бүтээлд гэр бүлийн эрх зүйн үндсэн асуудлын хүрээнд гарсан өөрчлөлт, гэр бүлийн дотоод асуудлыг гэр бүлийн гишүүд харилцан тохиролцож шийдвэрлэх, төрөөс гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих, гэр бүлийн эрх зүйн хамгаалалтыг хэрэгжүүлэх, шүүхийн хэлбэр хэрэгжиж байгаа онцлогийг шүүхийн практик болон шийдвэрт үндэслэн гаргахыг зорьжээ. Мөн их дээд сургуулиудад гэр бүлийн эрх зүйн хичээлийг заахад сургалтын хэрэглэгдэхүүн болох үүднээс тухайн салбар эрх зүйн онолын үндсэн асуудлыг сэдэв тус бүрт тодорхойлж энэ хичээлийн хүрээнд олсон мэдлэгээ шалгах сорил, хяналтын асуултыг багтааж гэр бүлийн эрх зүйн асуудлыг судлах хүн бүрт зориулжээ.

67.404.4

Д-62

X3C 20333-20342



Үзэн ядалтын гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх нь: Практик гарын авлага.- УБ.: 2014.- 116х.- ISBN 978-92-9234-899-1.

Үзэн ядалтын гэмт хэрэг нь ялгаварлан гадуурхах, үл тэвчих сэдэлтээр үйлдэгддэг эрүүгийн үйлдэл бөгөөд хувь хүмүүсийн хүний эрхэнд халдаад зогсохгүй нийгмийг бүхэлд нь хамарсан зөрчил, хүчирхийлэлд хүргэх төрлийн гэмт хэрэг юм. Энэхүү гарын авлагыг Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллага болон Олон улсын прокуроруудын


холбоо хамтран боловсруулжээ.

67.408

Ү-75

X3C 20461-20470

Лүндэндорж Н. **Шүүх эрх мэдэл**.- УБ.: Мөнхийг үсэг, 2017.- 164х.- ISBN 978-99978-0-951-3.




Зохиогч энэ бүтээлээрээ шүүх эрх мэдлийн онолын суурь ойлголтыг эрх зүйн ерөнхий онол, Үндсэн хуулийн эрх зүйн онолын үүднээс нэгтгэн дүгнэж шүүх эрх мэдлийн мөн чанар, онцлог, агуулга, багтаамжийг судлан тодорхойлсноороо Монгол улсад шүүхийн эрх зүйг цаашид хөгжин бэхжихэд чухал ач холбогдол өгчээ.

67.71(1)

Л-87

X3C 20426-20435



Эванс К. **Өмгөөллийн алтан дүрэм** / Орч. П.Оюундэлгэр; Ред. Ж.Эрдэнэбулган, З.Сүхбаатар.- УБ.: Адмон принт, 2017.- 143х.- ISBN 978-99929-2-487-9-7.

Энэхүү ном нь практикт суурилсан, сонирхолтой зөвлөгөөнөөс бүрдсэн бөгөөд шүүх хуралдаан болон алдаанаасаа суралцахаас өмнө бидэнд урьдчилан сэргийлж таниулсан 80 гаруй зааварчилгаануудыг өгүүлснээс гадна өмгөөлөгчийн заавал дагаж мөрдөх дүрэм, өмгөөллийн сэтгэл зүй, гэрчийг асуух, эсрэг талын гэрчийг асуух зэрэг бүлгүүдийг багтаажээ.

67.75

Э-12

/ХЗС-5ш/

ЭШФ Т-20597-20598

ЦЭРГИЙН ШИНЖЛЭХ УХААН

Батсүрэн Б. **1911-1913 оны Монгол цэргийн тухай өгүүллүүд** / Ред.Н.Хишигт.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 131х.- ISBN 978-99978-1-639-9.

Монгол улсын цэргийн түүхэнд холбогдох 1913 оны “Таван замын цэрэг” хятадын цэрэгтэй дайтсан түүх, түүнчлэн Ховд, Цагаан түнгэд манж-хятадтай тулалдсан түүх, XX зууны эхэн үед тусгаар тогтнолоо сэргээн мандуулсан Монгол улсын шинэ зэвсэгт хүчний цэрэг зэвсэглэлийн түүхийг өгүүлэхийг зорьсон судалгааны өгүүллүүд оржээ.

68.4(1)

Б-34

/НУН унш-7ш, ГНОФ-10ш/

Т-20582-20584



СОЁЛ. ШИНЖЛЭХ УХААН. ГЭГЭЭРЭЛ



Соёлын үг хэллэгийн товч тайлбар толь / Төслийг гүйцэтгэсэн. Д.Отгонтуяа, Г.Нандинбилиг, Д.Нямдорж; Орчуулгыг хян. Б.Уранбаясгалан, Т.Күк, Ж.Долинса.- УБ.: МУИС пресс, [2017].- 210х.- ISBN 978-99978-58-19-1.

С.Дуламын "Цагаан сарын бэлгэдэл" номоос тулгуурлан монгол англи хэлээр гарч буй энэхүү товч тайлбар тольд дараах зүйл багтсан болно. Үүнд: Цагаан сарын соёлын тайлбар толь, цагаан сарын соёлын 400 орчим үг хэллэг, Монгол соёлын 700 орчим үг хэллэг, цагаан сарын бэлгэдэл, Монголчуудын аман уламжлалт үг хэллэг, битүүний найрын ерөөл зэргийг тайлбарласан байна.


71я2

С-52

/НУН унш-3ш, ГНОФ-5ш/

ЭШФ Б-27017-27018

Дэлгэрэхцээг Ц., Энхжаргал П. **Японы боловсролын түүх** / Ред. Т.Мөнхцэцэг.- УБ.: Удам соёл, 2017.- 253х.- ISBN 978-99973-73-63-2.



Аливаа улсын хөгжлийн түлхүүр нь ард иргэдийн боловсрол юм. Энэхүү номд Японы боловсролын хөгжлийн түүхийг эрт үе, дунд үе, ойрхи үе, орчин үе гэсэн түүхэн үечлэл, боловсролын үзэл баримтлал, боловсролын байгууллага, хөгжлийн онцлогийг голлон авч үзжээ. Мөн манай орны боловсролын хөгжилд тус нэмэр болох үүднээс Японы боловсролын уламжлал, шинэчлэл, удирдлага зохион байгуулалт, боловсролын агуулга, багш суралцагчидтай холбоотой асуудлуудыг тусгасан болно.

74(5Яп)

Д-88

/НУН унш-5ш, ГНОФ-3ш/

ЭШФ Т-20495-20496



Даваа Ж. **Сургалтын технологи**. - УБ.: Артсофт, 2017.- 98х. (Монгол Улсын Их Сургууль). - ISBN 978-99978-1-558-3.

Энэхүү ном нь сургалтын технологи, түүний бүтэц, зорилго, зорилт, агуулга, арга зүй, сургалтын сэтгэл зүй, орчин болон сургалтын технологийн загварууд, интерактив, модуль, инноваци, кейс сургалт зэрэг агуулгыг багтаажээ.

74.202.4

Д-121

/НУН унш-7ш, ГНОФ-10ш/

ЭШФ Б-27167-27169

Аав, ээжийн ном / Э.Дуламсүрэн, Д.Баттогтох, Л.Отгонсүрэн ба бус.; Хян. Ц.Түвшинтөгс.- УБ.: 2017.- 225х.- ISBN 978-99978-875-2-8.



Хүүхдийг улс нийгмээрээ хайрлан дээдлэх уламжлалт үзэл санаа Монголын нийгэмд эртнээс эдүгээ хүртэл түгээмэл оршсоор иржээ. Энэ нь хүүхэд, өсвөр үеийнхнийг цөхрөл, ганцаардал, гансрал, хүнийсэл зэрэг нийгмийн суурь эрсдэлүүдээс хамгаалж, эрүүл энх өсөн бойжих, сурч боловсрох боломжийг олгож байдаг. Эдүгээ үндэсний уламжлал ба даяаршлаас үүдэлтэй соёл шинэчлэлийн зааг дээр Монгол хүүхдийн хөгжил төлөвшлийн талаар санаа бодлоо солилцож, хүүхдээ гэр бүл, улс орны эрх ашигт нийцүүлж хүмүүжүүлэх нь нэн тулгамдсан асуудал болж байна. Энэ үүднээс “Аав, ээжийн ном” бүтээжээ.

74.9

А-10

/НУН унш-3ш/

ЭШФ Б-25045-25046

ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГЛСЭЛ

Зулькафиль М. **Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд: Боть-7: Монголын олон нийтийн мэдээлэл:** Нэг намын үзэл суртлаас олон ургальч үзэл хүртэл / Ред. Л.Норовсүрэн, Т.Баасансүрэн.- УБ.: Удам соёл, 2017.- 300х- ISBN 978-99978-872-0-7.

Энэ бүтээл нь иргэний мэдээллийн нийгмийн мөн чанар, мэдээллийн нийгэм дэх ОНМХ-ийн онцлог, сүүлийн 10 жилд манай ОНМХ-ийн үйл ажиллагаанд гарсан өөрчлөлт, чиг хандлага, сэтгүүлчийн ур чадвар, сэтгүүл зүйн сургалт, судалгаанд гарсан шинэлэг хандлага зэрэг өргөн хүрээг хамарчээ.

76.0(1)

3-80

/НУН унш-7ш, ГНОФ-5ш/

ЭШФ Б-27102-27104

Зулькафиль М. **Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд: Боть-8: Сэтгүүлчийн мэргэжил:** Өчигдөр, өнөөдөр, маргааш / Ред. Ч.Чойсамба.- УБ.: Удам соёл, 2017.- 300х.- ISBN 978-99978-872-1-4.

“Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд” цувралын 8 дахь боть хэдлэгдэн та бүхний гарт хүрч байна. Энэхүү бүтээл нь сэтгүүлчийн мэргэжлийн загвар, тодорхойлолт, оюуны үйл ажиллагааны соёл, түүнийг идэвхжүүлэх арга барил, мэргэжлийн парадокс болон логик зөрчил, бэрхшээлүүдийн талаар залуу сэтгүүлчид, сэтгүүлч мэргэжлээр суралцагч оюутнууд, сэтгүүл зүй судлаачид мөн багш нарт гарын авлага болох юм.

76.0

3-80

/НУН унш-7ш, ГНОФ-5ш/

ЭШФ Б-27105-27107



Зулькафиль М. **Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд: Боть-9: Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онол, практик** / Ред. Ч.Чойсамба.- УБ.: Удам соёл, 2017.- 300х.- ISBN 978-99978-872-2-1.

Энэхүү бүтээлд эрэн сурвалжлах сэтгүүл зүйн талаарх ойлголтын онол, практик, арга зүйн талаар тодорхой төсөөлөл өгөх, эрэн сурвалжлага хийх арга зүй, Монголын эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжил, өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаар бичжээ.


76.0

3-80

/НУН унш-7ш, ГНОФ-5ш/

ЭШФ Б-27108-27110

Зулькафиль М. **Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд: Боть-10: Сэтгүүлчийн хөдөлмөр: Ёс зүй, хариуцлага, үнэлэмж** / Ред. Т.Баасансүрэг, Б.Болд-Эрдэнэ.- УБ.: Удам соёл, 2017.- 300х.- ISBN 978-99978-872-3-8.



“Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд”-ийн 10 дахь боть болох “Сэтгүүлчийн хөдөлмөр: Ёс зүй, хариуцлага, үнэлэмж” нэмээх энэхүү бүтээл нь үндсэн 3 бүлэгтэй бөгөөд сэтгүүлчийн ёс зүй, ур чадвар, бичлэгийн төрөл, сэтгүүлчдийн бүтээлийн тухай өгүүлэл, шүүмж, бодол эргэцүүллийг тусгасан байна.

76.01

3-80

/НУН унш-7ш, ГНОФ-5ш/

ЭШФ Б-27111-27113

ХЭЛ ШИНЖЛЭЛ



Пагва Т. **Хэл шинжлэлийн удиртгал** / Ред. А.Лувсандэндэв.- Здахь хэвл.- УБ.: Удам соёл, 2016.- 232х.

Монгол хэл шинжлэлийн сор бүтээлүүдийн нэг болох энэ ном нь анх хэвлэгдсэн цагаасаа үе үеийн хэл шинжлэлийг шимтэн судлагч, суралцагсад, сонирхогчдын ширээний ном болсоор иржээ. “Хэл шинжлэлийн удиртгал” номын агуулга нь авиазүй, үгийн сангийн сургааль ба үгийн утга зүй, хэлний зүй, олон хэлийг ангилахуй ба хэлний гарал гэсэн үндсэн 4 бүлэгтэй бөгөөд энэ удаагийн гурав дахь хэвлэл нь уг номын агуулга, бүтэц, найруулгыг өчүүхэн төдий ч өөрчлөөгүй бөгөөд өнөөгийн уншигчдын эрэлт хэрэгцээнд зориулан зөвхөн эрдэмтэн зохиолчийн анхны эхээр нь цахимд оруулан, мөн ном болгон хэвлүүлсэн байна.


81

П-11

/НУН унш-5ш, ГНОФ-7ш/

Б-27099-27101

Гэндэндарам Ж., Сүрэнжав Ш. **English grammar: Anthology of Mongolian poetry: Зуун найман эрдэнэсийн эрих.**- УБ.: Бэмби сан, 2017.- 324х. (Gems of wisdom-21)



Англи хэлний дүрмийн энэхүү номыг англи хэл дэвшин суралцагчид болон багш нарт зориулжээ. Гэхдээ эхлэн суралцагсад ч ашиглах бүрэн бололцоотой бөгөөд Англи-английн дүрмийг нэмэлт болгон авсан байна. Мөн нэртэй зохиолчдын бүтээлүүдийг англи хэл дээр орчуулан нийтэлсэн нь англи, монгол хэллэгийг тулган үзэхэд хэрэгтэй юм.

81.2Англ

Г-93

ЭШФ Б-26991-26992



Бадамсүрэн Б. **Эх хэл-хэрэглээ**: Зөв бичиж сурахад зориулав.- УБ.: Оюунлаг принт, 2017.- 80х.- ISBN 978-99973-3-457-2.

Энэхүү ном нь бичиг үсгийн боловсрол сайтай иргэн болоход хүүхэд, залууст зориулсан бөгөөд монгол хэлний дүрмийг жишээ үгийн хамт оруулж өгсөнөөрөө чухал ач холбогдолтой болжээ. Монгол хэлний зөв бичих зүйн дүрмийг хүн бүр, хүүхэд бүр заавал чээжлэх, чээжээр мэдэж

байх албагүй. Гэхдээ гол гол дүрмийг утгачлан ойлгоод, үгсийг тогтоон нүдэлж чадвал таны амьдралд "эх хэл" маань жинхэнэ "хэрэглээ" болох юм.

81.2М-9

Б-15

/НУН унш-3ш/

ЭШФ Б-27068-27069

Бямбаханд Ч. **Монгол хэлний орон цагийн харьцааны нэрийн утга, бүтцийн онцлог** / Ред. М.Базаррагчаа.- УБ.: Битпресс, 2017.- 264х.- ISBN 978-99973-76-99-2.



Орон цагийн харьцааны нэрийн судалгааг тодорхой болгосноор бусад үгсийн аймагт илрэх орон цагийн утгын ялгааг тодотгон гаргахад чухал үүрэгтэй юм. Тус номонд монгол хэлний орон цагийн харьцааны нэрийг бусад үгсийн аймгаас ялгарах шинж, орон цагийн харьцааны ба харьцааны бус нэрийн утга, хувиргал, хэлбэрийн хувиргалыг хоршоо үг, шууд бус нэрлэлтэнд хэрхэн илрэх онцлог зэргийг авч үзжээ.

81.2М-2

Б-98

/НУН унш-3ш, ГНОФ-3ш/ ЭШФ Т-20549-20550



Гаадамба Ш. **Монголын нууц товчооны үг хэллэгийн тайлбар** / Ред. Г.Билгүүдэй.- 2дахь хэвл.- УБ.: Соёмбо принтинг, 2016.- 334х.- ISBN 978-99962-75-98-2.

“Монголын нууц товчоо” нь түүх, утга зохиолын хосгүй дурсгал төдийгүй дунд үеийн монгол хэлний чухал баримт юм. Эрдэмтэн Ш.Гаадамба нь “Монголын нууц товчоо”-ны судлалаар олон жил ажиллаж уг дурсгалт бичгийн утга тодорхойгүй олон үг хэллэгийг Монгол аман зохиол, угсаатны зүй, зан үйл, эртний утга зохиолын жишээн дээр тулгуурлан тайлбарласан байдаг ба 1990 онд хэвлүүлсэн Монголын нууц товчоо: Худам (язгуур эртний) монгол бичгээр монгол бичиг, утга судлалын үүднээс төсөөлөн нягталж сэргээсэн эх, тайлбар хэмээх бүтээлээс үг, хэллэгийн тайлбарт зориулсан хэсгийг нь тусгай толь бичиг болгон дахин хэвлэсэн байна. Зохиогч "Монголын нууц товчоо"-г ийнхүү худам монгол бичгээр төсөөлөн сэргээн 691 үг хэллэгт тайлбар хийхдээ уг зохиолд тохиолдох дарааллаар нь дэсэлснийг монгол кирил бичгийн дараалалд оруулж, хуучин дэс дарааллын цэсийг толины төгсгөлд хавсаргажээ.

81.2М-4

Г-10

/НУН унш-2ш/

ЭШФ Т-20546-20548

Баярмаа Ц. **Англи хэлний өгүүлбэр зүй** / Хян. Л.Одонтуяа.- УБ.: Удам соёл, 2017.- 268х.- ISBN 978-99978-0-928-5.




Энэхүү номыг англи хэлний багш оюутан, магистрант, докторант бүх мэргэжлийн судлаач болон олон нийтэд зориулан гаргаж байна. Тус номд англи хэлний өгүүлбэр зүйн ойлголтуудыг монгол хэлээр тайлбарласан тул англи хэлний хэлзүй, өгүүлбэр зүй, унших дадал, бичих дадал, текст анализ болон орчуулгын хичээлд ашиглах боломжтой юм.

81.2Англ

Б-38

/НУН унш-5ш, ГНОФ-7ш/ ЭШФ Б-27058-27060

АМАН ЗОХИОЛ СУДЛАЛ



Катуу Б. ба бус. **Монгол аман зохиолын туурвил зүй** / Т.Баясгалан, Ч.Заяасүрэн; Ред. Р.Чүлтэмсүрэн.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 246х.- ISBN 978-99978-52-34-2.

Туурвил зүй нь уран зохиолын дүрслэн илэрхийлэх арга хэрэглүүрийн тогтолцоог судалдаг утга зохиолын онолын бүрэлдэхүүн хэсэг юм. Өргөн утгаараа туурвил зүй гэдэгт утга зохиолын онол бүхэлдээ харьяалагддаг бол явцуу утгаараа уран сайхны бүтээлийн хэлийг судалдаг гэж үздэг.

Энэхүү бүтээлд Монгол аман зохиолын аман яруу найргийн төрлүүдээс тууль, магтаал, сацал, мялаалгын зан үйлийн шүлэг гэсэн төрлийг онцлон авч, тэдгээрийг хэрхэн туурвин бүтээсэн асуудлыг дүр бүтээх уламжлал, хэл найруулга, шүлгийн уран сайхны онцлог талаас нь судлан шинжилсэн болно.

82.3(1)

К-29

/НУН унш-2ш/

ЭШФ Т-20488-20489

Катуу Б. **Дөрвөд аман зохиолын чуулган** / Хян. С.Нэргүй.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 564х.- ISBN 978-99978-4-009-7.



Дөрвөдүүд нь нэн эртнээс аман зохиолын төрөл зүйл, зан үйл, түүх, соёлоор ихээхэн баялаг бөгөөд түүнийгээ хэдэн зуун дамжуулан өвлөн хадгалж ирсэн угсаатан ястан юм. Ардын аман зохиолын төрөл зүйл бүхэн хэрэглээ болоод учир зүйн өөр өөр зориулалттай байхаас гадна уран сайхны хувьд төгс боловсорсон байдаг байна. Энэ бүтээлд дөрвөд ястны домог үлгэр, баатарлаг тууль, домог хууч яриа, ерөөл магтаал, домогт дуу, ардын дуу, кокир дуу, бөө мөргөлийн дом шившлэг, зан үйлийн холбогдолтой аман зохиол зэргийг багтаажээ.

82.3(1)

К-29

ЭШФ Т-20501-20502

УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ

Ганболд Д. **Ринчиний Чойномын яруу найргийн эх бичгийн судалгаа** / Хян. Д.Цэдэв.- УБ.: Жиком пресс, 2017.- 380х.- ISBN 978-99978-60-06-4.

Түүх соёлын дурсгалыг хадгалж хамгаалах, өвлүүлж үлдээх нь улс үндэсний оюуны хөгжлийн төвшинг тодорхойлох нэгэн хэмжүүр юм. Энэ үүднээс оюуны хөгжлийн төвшинг тогтооход хамаарах олон зүйлийн дотор үе үеийн бичгийн мэргэдийн үлдээсэн гар бичмэлүүд нь бичиг соёлын баримтат өв бөгөөд судлаач энэхүү бүтээлдээ Р.Чойномын гар бичмэлийг судалж үүгээрээ XX зууны Монголын утга зохиолын хөгжилд Р.Чойномын байр суурийг үнэн зөв эзлүүлэхэд бодит алхам хийжээ. Энэ судалгаа зөвхөн Р.Чойномын яруу найргаар үл барам бусад олон төрлөөр бичсэн зохиолуудыг нь шинжлэх эхлэл болж байна.

83

Г-21

/НУН унш-3ш/

ЭШФ Б-25042-25043

Утга зохиолын судлал шинжлэл: Цуврал-12. Уран зохиолын тухай яриа-2 / Д.Галбаатар, С.Энхбаяр, Г.Батсуурь ба бус.- УБ.: Жиком пресс, 2017.- 242х.- ISBN 978-99978-60-11-8.




“Утга зохиолын судлал шинжлэл” цувралын эхний найман ном Орос, Америкийн зохиолч В.Набоковын “Гадаад уран зохиолын лекц”-ээр эхэлсэн бол С.Энхбаярын орчуулгаар онолын өгүүллүүд, До.Цэнджавын шинжлэл, Шопенгауэрийн бүтээлийн эмхэтгэл, театр шинжлэл гээд сэдэв, чиглэлийн хүрээ тэлж эхэлжээ. Энэхүү 12-р цувралд манай утга зохиолын голлох судлаач, болох Д.Галбаатар, С.Энхбаяр мөн залуу үеийн судлаач Г.Батсуурь, Х.Чойдогжамц нарын судлал шинжлэлийн өгүүллүүд оржээ.

83

У-57

/НУН унш-7ш/

ЭШФ Б-24990-24992



Набоков В. **Гадаадын утга зохиолын лекцүүд:** Цуврал-5,6 / Орч. Ц.Цэнгэл; Ред. О.Содномпил.- УБ.: Жиком пресс, 2017.

Владимир Владимирович Набоков (1899-1977) бол XX зууны өрнөдийн уран зохиолын содон төлөөлөгч бөгөөд Орос гаралтай Америкийн зохиолч юм. В.Набоковын зохиол бүтээл нь зайлшгүй унших бүх цаг үеийн сонгодог номын жагсаалтанд бичигдсэн байдаг байна. Өмнө нь “Гадаадын утга зохиолын лекц” 1-4-ийг толилуулсан бол энэ удаа М.Прустын “Сваны зүг”, Р.Л.Стивенсон “Доктор Жекил болоод Мистер Хайдын хачирхалтай түүх” зохиолуудад задлан шинжлэл хийсэн байна.

83.3


Н-12

/НУН унш-7ш, ГНОФ-2ш/

Цуврал-5: Пруст “Сваны зүг”.- 100х.- ISBN 978-99978-60-13-2 ЭШФ Б-24978-24980

Цуврал-6: Стивенсон “Доктор Жекил болоод мистер Хайдын хачирхалтай түүх”.-
90х.- ISBN 978-99978-60-10-1 ЭШФ Б-24981-24986

Барт Р. **Зохиогчийн үхэл:** Утга зохиолын судлал шинжлэл: Цуврал-15 /
Орч. Ж.Отгонбаатар; Ред. О.Содномпил.- УБ.: Жиком пресс, 2017.- 126х.-
ISBN 978-99978-60-29-3.




Францын өвөрмөц сэтгэгч, философич, утга зохиол судлаач Ролан Барт бол
XX зууны структурализм, постмодернизм, постструктурализмийн томоохон
төлөөлөгч юм. Энэ удаагийн “Утга зохиолын судлал шинжлэл” номын 15-р
цувралаар Р.Бартын утга зохиолын шинжлэл хийсэн бүтээлүүдийг орчуулан
хүргэж байна.

83.3(0)

Б-31

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Б-27053-27055



Бахтин М. **Эпос хийгээд роман:** Утга зохиолын судлал шинжлэл: Цуврал-
13 / Орч. Н.Пүрэвдагва; Ред. О.Содномпил.- УБ.: Жиком пресс, 2017.- 290х.-
ISBN 978-99978-60-28-6.

“Утга зохиолын судлал шинжлэл” цувралын энэ дугаараар Оросын
философич, Европын соёл болон урлаг, утга зохиолын онолч Михайл
Михайлович Бахтины “Роман дахь цаг хугацаа, хронотопын хэлбэр”, “Эпос
хийгээд роман” гэсэн гол хоёр бүтээлийг орчуулан хүргэж байна.


83.3(0)

Б-35

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Б-27061-27063

Шопенгауэр А. **Маргаанд ялах урлаг:** Утга зохиолын судлал шинжлэл:
Цуврал-14 / Орч. Л.Будгал; Ред. О.Содномпил.- УБ.: Жиком пресс, 2017.-
146х.- ISBN 978-99978-60-12-5.




Артур Шопенгауэр бол иррационалист философич хүн юм. Энэхүү
зохиолдоо А. Шопенгауэр маргаандаа ялах зорилго тавигчдад хэрхэн дэс
дараалалтай зорилгодоо хүрэх талаар тодорхой зааварчилгаа өгсөн байна.
Мөн “Parerga und Paralipomena” зохиолын “Бие дааж сэтгэн бодохуйн
тухай” хэмээх бүлэг, нэр өгөөгүй өөр нэг бүлгийг багтаасан төдийгүй
философчийн бусад зохиолуудаас хэсэгчлэн авсан ишлэлүүд, онч мэргэн үгсийг
оруулснаар санаа бодлоо товч тодорхой, эмх цэгцтэй, хурц цэцэн хэлбэрээр илэрхийлэх
урлагт суралцахад тус дэм болох юм.

83.3(0)

Ш-79

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Б-27075-27077



Зандраабайдий Х. **Дашзэвэгийн Сэнгээ** / Ред. С.Баяр, Ц.Гомбосүрэн, П.Очирбат, Б.Цэнддоо.- УБ.: Нэпко, 2017.- 250х.- ISBN 978-99978-51-21-5.

Монголын түүхийн онцгой үед амьдарч, нийгмийнхээ түүхэнд ул мөрөө үлдээн, оройлох үүрэгтнээс эхлээд системийн золиос, тогтцын үр шим болж явсан олон зүтгэлтнүүдийн намтар түүхийг сэргээн бичиж, үндэсний түүхээ зөв гольдрилд нь оруулах, түүхийн шинэчлэлийг хийх их үйлсийн эхлэл болох Хүмүүн хорвоо нийгэмлэгээс эрхлэн гаргаж байгаа “Түүхэн эрхэмүүдийн цадиг” цувралын энэ удаагийн хэвлэлд эрхэм зохиолч Дашзэвэгийн Сэнгээгийн уран бүтээлийн амьдралын түүхээс нь өгүүлжээ.


83.3(1)г

3-27

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

Б-27085-27087

Дашдоржийн Нацагдорж: Гэрэл зураг, баримт / Эмхт. Ч.Жачин, С.Чулуун.-УБ.: Адмон принтинг, 2017.- 80х.- ISBN 978-99978-0-293-4.



Энэхүү гэрэл зураг, баримтын цомог нь Монголын шинэ үеийн уран зохиолыг үндэслэгч, зохиолч, судлаач, Шинжлэх ухааны хүрээлэнгийн Түүхийн салбарын эрхлэгч Боржигон овогт Дашдоржийн Нацагдоржийн холбогдолтой гэрэл зураг, баримтаас бүрдсэн бүтээл болно. Урьд өмнө нь нийтлэгдсэн болон анх удаа хэвлэгдэж буй эдгээр зураг баримт нь Нацагдорж судлалыг сонирхон судлагчид, оюутан, сонирхогч хэн бүхэнд зориулагджээ.

83.3(1)я6

Д-39

/НУН унш-3ш/

ЭШФ Б-25009-25011



Цэнджав До. **Утга зохиолын судлал шинжлэлийн өгүүллүүд**: Цуврал-10 / Ред. О.Содномпил.- УБ.: Жиком пресс, 2017.- 326х.- ISBN 978-99978-60-05-7.

XXI зууны Монголын уран зохиолыг цоо шинэ ирээдүй өөд хөдөлгөө хөгжүүлэе, шинэ залуу авъяас билигтнийг дэмжэе, уншигчдынхаа оюун санааны ертөнцийг өөрчилэе, зохиолчдынхоо ур чадварыг хөгжүүлэе гэвэл түүнийг хөдөлгөгч хүчин болсон уран зохиолын шинэ шүүмж шүүмжлэл болоод шинэ уран зохиолын судлалыг хөгжүүлэх юм. Хүмүүс анхныхаа шүлгийг барьсаар уран зохиолын хаалгыг татдаг бол До.Цэнджав өөрөө шууд шүүмж бичсээр орж ирсэн байна. Түүний шүүмж ур хийц, үг хэллэгийн илэрхийлэл сайтай, дэвшүүлсэн санаа шинэлэг, хурц тод, голчтой байдлаараа ялгардаг юм.

83.3(1)

Ц-95

/НУН унш-7ш, ГНОФ-4ш/

ЭШФ Б-24984-24986

Төвд, Монгол “Данжуур”-ын Дандины “Зохист аялгууны толь” / Төвд эхтэй нь харгуулан монгол бичгээс хөрвүүлж, тайлбар хийсэн Д.Сумъяа; Ред. Г.Билгүүдэй.- УБ.: Жиком пресс, 2017.- 678х.- ISBN 978-99978-0-482-2.



Энэхүү “Зохист аялгууны толь” хэмээх бүтээлийг VII зуунд эртний Энэтхэгийн Дандин зохиожээ. Энэтхэг, Төвд, Монгол, Хятад, Балба зэрэг Дорно дахины олон улс орны утга соёлын хүрээнд өргөн уламжлагдан тархаж, эдгээр улс орны утга зохиолын онолын сэтгэлгээнд хүчтэй нөлөө үзүүлсэн байдаг. Ингээд Төвд, Монгол “Данжуур”-ын эхийг хөрвүүлж төвд, монгол, шинэ үсгийн гурван эхийг хамтад нь толилуулж байна.

83.3(5Энэт)

T-56

/НУН унш-2ш/

ЭШФ Т-20485-20487

ГАДААДЫН УРАН ЗОХИОЛ



Өрнө Дорнын шилдэг өгүүллэгүүд / Орч. Т.Юмсүрэн; Хян. Ю.Дэлгэрмаа.- 4дэх хэвл.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 635х.- ISBN 978-99978-0-750-2.

"Өрнө Дорны шилдэг өгүүллэгүүд" хэмээх энэ номонд АНУ, Англи, Франц, ХБНГУ, Испани, Итали, ОХУ, Португали, Киргиз, Алжир, Эмнед Иемени, Голланд, Энэтхэг, Япон, Турк зэрэг дэлхийн 16 орны 41 зохиолчийн ерэн хэдэн шилдэг өгүүллэгийг орчуулан оруулсан болно. Дээрх орнуудын зохиолчдоос америкийн Уильям Фолкнер, Францын Жан Поль Сартр, А.Катю, Английн Жон Голсуорси, Оросын Иван Бунин, Энэтхэгийн Рабиндранат Таагуур, Японы Ясунари Кавабата, Кэнзабуро Оэ, Канадын Элис Манро нарын Нобелийн шагналтнуудаас гадна Киргизийн ардын зохиолч Чингиз Айтматов, Энэтхэгийн алдарт зохиолч Кришан Чандар, Прем Чанд, Ходжа Ахмад Аббас, Оросын Владимир Нобаков, Антон Чехов, Юрий Мамлеев, Голландын Анна Бламан нарын элдэв урсгал чиглэлээр бичсэн шилдэг өгүүллэгүүд орсон байна.


84(0)-44

Ө-90

/НУН унш-3ш, ГНОФ-4ш/

ЭШФ Б-25006-25008

Войнович В. Цэрэг Иван Чонкины амьдрал хийгээд ер бусын адал явдал: Хаан ширээнд санаархагч: Дэд дэвтэр. / Орч. Ж.Нэргүй.- УБ.: Жиком пресс, 2017.- 416х.- ISBN 978-99978-0-665-9.



Владимир Войнович нь Оросын уран зохиолын шинэ эрэл хайгуулыг дэлхийн түвшинд зарласан өвөрмөц уран бүтээлч юм. Чонкины бол авхаалж самбаагүй, хэзээний л хөгөө чирч явдаг уншигч бүрийн дотоод сэтгэлийн хүндэтгэлийг хүлээж, хайрыг татсан жирийн цэргийн тод томруун дүрүүдийн нэг билээ.

84(2Орос)-44

В-65

/НУН унш-3ш/

ЭШФ Б-24995-24996



Гамзатов Р. **Миний Дагестан** / Орч. М.Цэдэндорж; Ред. Б.Пүрэвдорж.- УБ.: Соёмбо принтинг, [2017].- 507х.- ISBN 978-99973-3-849-5.

“Миний Дагестан” зохиол нь Расул Гамзатовын анхны үргэлжилсэн үгийн зохиол юм. Нэрт яруу найрагч, орчуулагч Мишигийн Цэдэндорж далаад оны дундуур Дагестаны хөвүүн Расул Гамзатовын “Миний Дагестан” хэмээх энэхүү алдарт номыг монгол хэлнээ хөрвүүлж хойч үедээ үлдээжээ. Энэхүү зохиолоос жинхэнэ эх оронч хүн төрсөн газар нутгаа, төрсөн нутгийнхаа хүн ардын зан заншлыг хичнээн сайхан магтан дуулсныг мэдэх болно.

84(2Орос)

Г-20

/НУН унш-7ш/

ЭШФ Б-26948-26950

Евтушенко Е. **Надаас та нар намайг булаагаад авчихжээ...**: Сонгомол шүлгүүд / Орч. Ж.Нэргүй.- УБ.: Жиком пресс, 2017.- 136х.- ISBN 978-99978-0-836-3.



Танхил, танхай Евтушенкогийн тэрсүүд үзэл бүр 7-р ангиас нь эхэлжээ. Олон хүүхдэд муу тавьсан ангийн журналыг шатаасан хэргээр сургуулиасаа хөөгдөж хар ажил хийж байх үедээ 1952 онд яруу найргийн анхны түүвэр "Ирээдүйн хайгуулчид"-аа гарган улмаар 20-хон насандаа Зөвлөлтийн зохиолчдын хорооны гишүүнээр элссэн байна. Евтуншенкогийн шүлэг найргийх нь үгийн бүтцийг аваад үзвэл шинэ эстрад маягийн үг зохион хэрэглэх дуртай нэгэн. Түүний шүлгүүдийг монгол хэлнээ хөрвүүлэн уншигч танд өргөн барьж байна.

84(2Орос)-5

Е-21

/НУН унш-3ш/

ЭШФ Б-24993-24994



Салли Г. **Хар цагаан** / Орч. М.Алтантулга; Ред. Д.Хүрэлхүү.- УБ.: НЭПКО., 2016.- 362х.- ISBN 978-99973-66-68-9.

Орчин үеийн Европт хүмүүстэй мөр зэрэгцэн хар, цагаан шулмууд нууцлагхан амьдарч, хоорондоо үхэх, сэхэхийн аймшигтай тэмцэл явуулсаар иржээ. Хүүхэд наснаасаа өнчрөл, хагацал, бусдад гадуурхагдахын зовлонг ханатал амссан Натан хүүгийн эх нь өөрийгөө эмчилдэг шидтэй цагаан шулам, харин эцэг нь бүх цагаан шулмын зүрхэнд шар ус хуруулсан хамгийн хүчирхэг хар шулам ажээ. Тэрээр 17 нас хүрэхээсээ өмнө эцгээ олж уулзан, гурван шид увдисыг нь өвлөн авахгүй аваас үхэгсэдийн орон руу илгээгдэх тавилантай ажээ.


84(4ИхБр)-44

С-22

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Б-27088-27090

Ашваагхооша. **Буддха багшийн цадиг оршвой**: Буддхачарита / Орч. Ж.Гэндэндарам; Хян. Ш.Сонинбаяр.- УБ.: Бэмби сан, 2017.- 344х. (Gems of wisdom Цуврал-8)




Буддхын шашны гүн бишрэлт яруу найрагч Ашваагхоош бээр “Буддхын цадиг” хэмээх Буддхын амьдрал болон түүний үзэл бодол, сургааль номлолыг тусгасан яруу найраглалыг зохиосон байна. Энэ зохиолд Буддха яагаад хааны ордон, авгай хүүхдээ орхин тэнэж, ямар газар орноор явж юу үзэж судалсан, сургаал номоо хэдийд хаана тавьсан, нирваан дүрийг хэдийд хаана олсон зэргийг өгүүлнэ.

84(5Энэт)

А-94

ЭШФ Б-26965-26966



Вээдавъяаса М. **Их дайн**: Махаабхаарата / Орч. Ж.Гэндэндарам; Хян. Г.Аким.- УБ.: Бэмби сан, 2017.- 504х. (Gems of wisdom Цуврал-3)

Энэхүү Махаабхаарата нь дэлхийн яруу найрагийн эрдэнэсийн алтан санд зүй ёсоор бүртгэгдсэн бүтээл юм. Энэ хорвоо дээр эд хөрөнгө, зэрэг тушаалын хүсэл тачаал шиг аймшигт дайсан байдаггүй бөгөөд үүний төлөөх ах дүүсийн хоорондын дайсагнал хийгээд үнэнээр явбал үхэр тэргээр туулай гүйцэнэ гэдэг шиг үнэн шударга зан байдал ямар ч үед ялж


гардгийг энэ сударт өгүүлдгээрээ их сургамжтай болой.

84(5Энэт)

В-97

ЭШФ Б-26955-26956

Гаалидаас Ш., Бандита Ш. **Шакундалаа = Ухаан цэлмээгч утгын эрхи** / Орч. Ж.Гэндэндарам; Хян. Т.Содномдаржаа, Г.Мэнд-Ооёо.- УБ.: Бэмби сан, 2017.- 387х. (Gems of wisdom Цуврал-6)




Эртний Энэтхэгийн соёлын “Алтан үеийн” хамгийн алдарт сонгодог бүтээлүүдийн нэг болох Гаалидаасын “Шакундалаа” жүжиг дэлхийн олон хэлнээ орчуулагдсан бөгөөд монгол хэлнээ орчуулан гаргаж байна. Энэхүү зохиолд Хаан дээдэс, хатамжлагч охин хоёрын хайр дурлалыг харуулсны зэрэгцээ тэдний нийлэн амьдрахад тохиолдсон саад тотгорыг өгүүлсэн байна.

84(5Энэт)

Г-10

ЭШФ Б-26961-26962



Дулсийдааса Г. **Шрираамачандраан тууж оршвой** / Орч. Ж.Гэндэндарам; Хян. Д.Цэрэнсодном.- УБ.: Бэмби сан, 2017.- 704х. (Gems of wisdom Цуврал-2)

Энэхүү тууж нь Хинди утга зохиолд төдийгүй дэлхийн соёлын санд дээгүүр байр эзэлдэг ховорхон бүтээл юм. Ертөнцөд төрсөн ах дүү байна гэдэг хайрын ариун үнэн тангарагтай байдгийг сургахдаа хаан ширээгээ хүртэл

бие биендээ найр тавин өгч буйг харуулахын зэрэгцээ үнэн хайр сэтгэлтэй хосууд бие биений төлөө ямар их гай зовлонг амсаж түүнийхээ үрээр амьдралын эцсийн мөчөө жаргалтай өнгөрөөж байгааг тодоос тод харуулжээ.

84(5Энэт)

Д-64

ЭШФ Б-26953-26954

Нандаа Г. **Төөрсөн хувь тавилан = Нүдэн золио** / Орч. Ж.Гэндэндарам; Хян. Ц.Цэрэндулам, Ө.Шаравдорж.- УБ.: Бэмби сан, 2017.- 299х. (Gems of wisdom Цуврал-12)



Гулшин Нандаагийн романууд Энэтхэгийн уран сайхны кино болж үзэгч олны таашаалыг хүртэж байна. Түүний хорин зургаа дахь роман “Төөрсөн хувь тавилан” хэмээх энэхүү зохиолд хүн залуу насандаа хайр дурлалын давалгаанд алдаж онох нь байдаг бөгөөд нэгэн удаагийн алдаа нь амьдралд нөхөж баршгүй гарз хохирол учруулж түүнийг засаж залруулахад тун бэрхтэйг өгүүлсэн болно.

84(5Энэт)-44

Н-28

ЭШФ Б-26973-26974



Чанд Б. **Ядуугийн зовлон** / Орч. Ж.Гэнлэндарам; Хян. Т.Содномдаржаа.- УБ.: Бэмби сан, 2017.- 634х. (Gems of wisdom Цуврал-10)


Орчин үеийн Хинди үргэлжилсэн үгийн зохиолын хаан Брээм Чандын энэхүү романд хөдөөд феодалын эзний харьцаа ноёрхож, хотод хөрөнгөт ёсны харьцаа тогтсон байгаа нийгмийг дүрслэн гаргаж ийм нийгэмд амьдарч байгаа хүмүүсийн зовлон гачаалыг тал бүрээс нь тодруулан харуулж үүнээс гарах замыг нь заахыг хичээжээ.

84(5Энэт)-44

Ч-20

ЭШФ Б-26969-26970

Чанд Б. **Нэрэлхүүн гай** / Орч. Ж.Гэндэндарам; Хян. С.Лхагважав.- УБ.: Бэмби сан, 2017.- 328х. (Gems of wisdom Цуврал-11)




Брээм Чандын “Эхийн сэтгэл”, “Нирмалаа бүсгүй”, “Хүний сэтгэл”, “Согтуурал” зэрэг олон романыг монгол хэлнээ орчуулан хүргэсэн билээ. Энэ удаа “Нэрэлхүүн гай” хэмээх романыг орчуулан хүргэж байна. Энд нэрэлхүү байх, айж хулчигнах, шударга бус үйлдэл хийх нь өөрийн болон бусдын амьдралыг хэрхэн хорлон сүйтгэж болдгыг өгүүлнэ. Гэхдээ алдсан эндсэнээ ойлгож чадваас амьдралаа дахин зөвөөр зохион байгуулж болохыг заажээ.

84(5Энэт)-44

Ч-20

ЭШФ Б-26971-26972



Шаштари А.Ч. ба бус. **Аабхаа = Нүгэл буян = Энгэр зөрүүлэхийн учир** / Г.Нандаа, К.Бандид; Орч. Ж.Гэндэндарам; Хян. Д.Чойжил, Б.Оргил.- УБ.: Бэмби сан, 2017.- 332х. (Gems of wisdom Цуврал-13)


“Аабхаа” зохиолд эхнэр, нөхөр салж болно гэвч салж сарнисныхаа учир шалтгааныг зөвөөр ухаарч эргэн нийлж болохыг өгүүлнэ. “Нүгэл буян” зохиолд нэгэн бүсгүй өргөсөн эцгийн ёс бус явдлыг үзэн ядаж, эцэст нь түүнийг алаад өөрөө таазын тавцан руу явж байхдаа би хүний бус ёсыг үгүй хийж хайрт хүнээ түүнд алуулахаас аварч яваа минь буян болой гэж бодож байгаа тухай өгүүлжээ. “Энгэр зөрүүлэхийн учир” зохиолыг 16-р зууны үед Энэтхэгийн Коока Бандид зохиожээ. Энэ номд авгай нөхөр энгэр зөрүүлнэ гэдэг хурьцал тачаал тайлах төдий асуудал биш энэ бол нийгэмд өөрсдийн хойчоо залгамжлах хүн бүтээж байгаа асар хариуцлагатай үйлдэл мөн гэдгийг түүний техник, урлагаар тодорхойлсон байна.

84(5Энэт)

Ш-10

ЭШФ Б-26975-26976

Шармаа В. **Таван сургамж**: Панчатантра / Орч. Ж.Гэндэндарам; Хян. Д.Цэрэнсодном.- УБ.: Бэмби сан, 2017.- 354х. (Gems of wisdom Цуврал-5)



Панчатантра буюу “Таван сургамж” хэмээх энэхүү зохиолыг аргын тооллын III-IV зууны үед Санскрит хэлээр зохиожээ. Хичнээн том хааны хүү, хичнээн баян чинээлэг айлын хүүхэд байлаа гээд эрдэм номгүй, ухаангүй бол хүний амьдралаар амьдарч чадахгүй бусдын доог тохуу, тоглоом болно гэдгийг энэхүү сударт өгүүлнэ.

84(5Энэт)

Ш-31

ЭШФ Б-26959-26590

МОНГОЛЫН УРАН ЗОХИОЛ



Бааст Б. **Ахтаан бүргэд бид гурав**. - УБ.: Хайтан студи, 2007.- 142х.

Энэ номонд Казахын нэрт яруу найрагч Ахтааны 100 насны ойд зориулж, түүний амьдрал, уран бүтээлтэй холбоотой дурсамж, өгүүлэл, айтыс, шүлэг, тэмдэглэл, зураг болон алдарт “Бүргэд” найраглалыг онцлон бүрэн эхээр нь оруулсан байна.

84(1)

Б-10


Б-27130-27131

Бааст Б. **Хадхүүгийн өдрийн тэмдэглэл буюу хөдөө болсон номын баяр:** Холбоо таван тууж. Цуврал-2.- УБ.: Соёмбо принтинг, 2004.- 327х.

Энэхүү тууж нь дотроо 10 бүлэг бөгөөд цөм чонын тухай төдийгүй зохиолч маань хүн чоно хоёрын хоорондох янз бүрийн сонирхолтой, хөгтэй, жигтэй учрал тохиолдлын тухай өгүүлжээ.

84(1)

Б-10



Б-27132-27133



Бааст Б. **Гэрийн, хээрийн хоёр хар амт:** Цуврал-3.- УБ.: <Хэвлэлийн газар байхгүй>, 2007.- 400х.

Зохиолчийн цуврал бүтээлийн энэ дугаарт дан чонын тухай тууж өгүүллэг, эртнээс сонирхож цуглуулсан чонотой холбоотой үлгэр, өгүүллэгүүд нь оржээ.

84(1)

Б-10


Б-27134-27135

Бааст Б. **Ганц хонгор азарга:** Цуврал-4.- УБ.: Соёмбо принтинг, 2008.- 609х.- ISBN 978-99929-4-130-8.

Энэхүү цуврал бүтээлд хүрээлэн буй байгаль орчны сэдвээр сүүлийн 30-40 жилийн хугацаанд зохиолчийн бичсэн өгүүллэг, шог хошин аястай болон кино жүжгийн зохиолын хэлбэрт оруулж бичсэн 35 өгүүлэл нь оржээ.

84(1)

Б-10



Б-27136-27137



Бааст Б. **Юмдүүжин:** Цуврал-8 / Ред. Х.Зандраабайдий.- УБ.: Хайтан студи, 2009.- 390х.- ISBN 978-99929-4-330-0.

Зохиолчийн цуврал бүтээлийн энэ дугаарт “Юмдүүжин” тууж болон найруулал, намтар, дурсамж, тэмдэглэл, сэтгэгдэл нь багтсан байна.

84(1)

Б-10

Б-27138-27139


Бааст Б. **Улаан хэрэм**: Цуврал-10 / Ред. Мөнхбайгаль.- УБ.: Мөнхийн үсэг, 2010.- 475х.- ISBN 978-99929-1-960-4.



Зохиолч цуврал бүтээлийнхээ энэ дугаарт “Улаан хэрэм” баримтат тууж, Цэрэнжавын Уламбаярт зориулсан дургтгал, тэмдэглэл, сэтгүүлчийн аян замын тэмдэглэл, захидлуудаа оруулжээ.

84(1)
Б-10

Б-27140-27141



Бааст Б. **Холбоо дөрвөн тууж**: Цуврал-11 / Ред. Мөнхбайгаль.- УБ.: Мөнхийн үсэг, 2010.- 683х.- ISBN 978-99929-1-834-9.

Зохиолчийн цуврал бүтээлийн энэ дугаарт “Хүрлээ”, “Хаврын салхи”, ”Цагаан Түнгийн намар”, “Эмээл дээр өнгөрүүлсэн дөрвөн жил” туужууд нь оржээ.

84(1)
Б-10

Б-27142-27143

Бааст Б. **Түмний минь хишиг**: Цуврал-12 / Ред. Мөнхбайгаль.- УБ.: Мөнхийн үсэг, 2011.-411х.- ISBN 978-99929-1-834-9.



Зохиолч цуврал бүтээлийнхээ энэ дугаарт Дорнод аймгийн ерөөлч, магтаалч Чимэдийн Жигмэд, Хөвсгөлийн цаатан Аюушийн Мижид, Ховд аймгийн Булган сумын урианхай Сийнагийн Буян, Баян-Өлгий аймгийн Сагсай сумын Хөх дэлхий хэмээгдсэн Аюуш, Төв аймгийн ерөөлч Баярын Дагва, Увс аймгийн алдарт туульч Увкагийн Батаа нарын тухай болон тэднээс сонссон үлгэр, тууль, дуу, ерөөл, магтаал, дурсамж, өгүүлэл, тэмдэглэлээ эмхэтгэн хэвлүүлжээ.

84(1)
Б-10

Б-27144-27145



Бааст Б. **Хар ус Цагаан сүү**: Цуврал-13 / Ред. Мөнхбайгаль.- УБ.: Мөнхийн үсэг, 2011.- 358х.- ISBN 978-99962-1-200-0.

Зохиолчийн цуврал бүтээлийн энэ дугаарт “Жаргалтайн дэлгэр дөчин жил”, “Ногоон бороо”, “Арвижихийн гэр бүл” зэрэг баримтат болон уран сайхны тууж, жүжиг, захидал, сэтгүүлчийн тэмдэглэл нь орсон байна.

84(1)
Б-10

Б-27146-27147

Бааст Б. **Хоёр буурал**: Цуврал-14 / Ред. Мөнхбайгаль.- УБ.: Мөнхийн үсэг, 2011.- 484х.- ISBN 978-99962-1-243-7.

Зохиолчийн цуврал бүтээлийн энэ дугаарт “Дөрвөн улирал, Дөрвөн учрал”, “Хоёр буурал”, “Алтан хуц”, “Мянган тэмээтийн хүү” зэрэг баримтат тууж, жүжиг, захидал, тэмдэглэл нь багтжээ.



84(1)
Б-10

Б-27148-27149



Бааст Б. **Чулуунцэцэг**: Цуврал-15 / Ред. Мөнхбайгаль.- УБ.: Мөнхийн үсэг, 2012.- 609х.-ISBN 978-99962-1-474-5.

Зохиолчийн цуврал бүтээлийн энэ дугаарт “Чулуунцэцэг” тууж болон хувийн захидлын өв сангаас нь оруулжээ.

84(1)
Б-10

Б-27150-27151


Бааст Б. **Хаана амьдрана даа хөөрхий...**: Цуврал-17.- УБ.: Мөнхийн үсэг, 2013.- 424х.- ISBN 978-99962-1-855-2.

Зохиолчийн цуврал бүтээлийн энэ дугаарт “Хаана амьдрана даа хөөрхий...”, “Хурим”, “Хураалгаагүй үнэмлэхийн түүх”, “Домогт баатар” туужууд, захидал, тэмдэглэл нь хэвлэгджээ.



84(1)
Б-10

Б-27152-27153



Бааст Б. **Цагаан чоно**: Цуврал-18.- УБ.: Мөнхийн үсэг, 2014.-459х.- ISBN 978-99973-2-355-2.

Зохиолчийн цуврал бүтээлийн энэ дугаарт “Цагаан чоно”, “Тэргэл сартай шөнө”, “Цөөвөр” туужууд, захидал, тэмдэглэл нь багтжээ.


84(1)
Б-10

Б-27154-27155


Бааст Б. **Дуртгал, дурсамж-Бодол эргэцүүлэл 2:** Цуврал-19 / Ред. Байгаль.- УБ.: Хайтан студи, 2014.- 848х.- ISBN 978- 99973-2-738-3.

Цуврал бүтээлийн энэ дугаарт зохиогчийн өөрийн дуртгал, дурсамж, найруулал, тэмдэглэл, ярилцлага, сурвалжлага, захидал, гэрэл зураг оржээ.

84(1)
Б-10



Б-27156-27157



Бааст Б. **Уянгаа Солонгоо хоёр:** Цуврал-20.- УБ.: Хайтан студи, 2015.- 431х.- ISBN 978- 99962-3-962-5.

Зохиолчийн цуврал бүтээлийн энэ дугаарт “Чонон саарал”, “Өгөөмөрийн Сүрэнжээ”, “Уянгаа Солонгоо хоёр” туужууд, зохиолчоос төр засгийн удирдлага болон бусад хүмүүст бичсэн захидлууд багтжээ.

84(1)
Б-10

Б-27158-27159


Бааст Б. **Гэгээн хайрын дууль буюу хэрэм тором хоёр:** Цуврал-21.- УБ.: Хайтан студи, 2016.- 518х.- ISBN 978- 99962-79-87-4.

Ардын уран зохиолч Б.Бааст гуайн цуврал бүтээлийн энэ дугаарт “Би 95 нас хүрвэй”, “Гэгээн хайрын дууль буюу Хэрэм, Тором хоёр” тууж, “Дурдатгал дурсамж-бодол эргэцүүлэл, ярилцлага, сурвалжлага, өгүүлэл, нийтлэл, өгүүллэг, захидал, тэмдэглэл орчуулга”-ууд нь багтжээ.

84(1)
Б-10



Б-27160-27161



Батжаргал Д. **Намайг дагадаг нар:** Шилмэл бүтээлийн түүвэр-1 / Хян. Д.Нямаа.- УБ.: Бэмби сан, 2017.- 287х.- ISBN 978-99978-817-7-9.

Яруу найрагч Долгорын Батжаргалын шүлгүүд нь цөөн үгтэй, богино мөртэй, хөгжөөнтэй өнгө аястай байдаг нь хүүхдийн унших, тогтооход хялбар байдаг юм. Энэхүү номд шилмэл шүлгийн бүтээлүүдийг нь уйгаржин монгол бичгээр хөрвүүлэн зэрэгцүүлжээ.

84(1)-5
Б-33

/НУН унш-5ш, ГНОФ-3ш/

ЭШФ Б-27013-24014

Батзаяа Б. **Лонхонд байсан шүлгүүд** / Ред. Н.Энхбаяр.- УБ.: TAGTAA publishing, 2017.- 87х.- ISBN 978-99978-1-589-7.



“Яруу найраг бол догдлол нь бодлоо олж, бодол нь үгээ оносны үр” гэж Америкийн яруу найрагч Роберт Фрост хэлсэн байдаг. Батхүүгийн Батзаяагийн шүлгүүд нь содон өнгө, тод хэл, яруу дуунаараа уншигч танд үгэнд хувилсан бодлууд, бодолд хувирсан догдлолуудыг мэдрүүлэх болно.

84(1)-5

Б-33

/НУН унш-3ш/

ЭШФ Б-27011-27012



Батзаяа Б. **Догдлолууд: Яруу найргийн түүвэр**.- УБ.: 2012.- 107х.- ISBN 978-99962-968-0-2.

Яруу найрагч Батхүүгийн Батзаяа өмнө нь “Баяртай, гуниг минь...” шүлгийн түүвэр номоо гаргасан бол энэ удаа 2010-аас 2012 онд туурвисан шүлгүүдээ “Догдлолууд” нэтрэйгээр гаргаж байна.

84(1)-5

Б-33

/НУН унш-3ш/

ЭШФ Б-27019-27020

Гэндэндарам Ж. **Нартай, сартай хорвоон аяг**.- УБ.: Бэмби сан, 2017.- 464х. (Gems of wisdom Цуврал-14)




Монгол улсын соёлын гавъяат зүтгэлтэн, Профессор Жамсрангийн Гэндэндарам нь Монголын зохиолчдын эвлэл, Монголын орчуулагчдын эвлэл, Монголын соёл, яруу найргийн академийн гишүүн юм. Уг номонд хүн амьдралдаа жаргал, зовлон, үнэн худал, сайн, муу эсэн бусын юмыг үзэж, амсаж, сонсдог бөгөөд тэр бүхнийг уран зохиолын хэллэгээр шүлэглэн дүрсэлжээ.

84(1)

Г-93

ЭШФ Б-26977-26978



Гэндэндарам Ж. **Алагхан хорвоо гэж...= Аз жаргалтай айл гэрийн амьдрахуйн ухаан** / Хян. Т.Намжил.- УБ.: Бэмби сан, 2017.- 348х. (Gems of wisdom Цуврал-15)

Ж.Гэндэндарам нь Энэтхэгийн уран зохиолыг эх хэлнээс нь хөрвүүлж та бидний гэр дээр хүргэсэн билээ. Энэ удаа тэрээр өөрийн туурвисан зохиолын түүврээ “Алагхан хорвоо гэж...” нэртэйгээр уншигчдын хүртээл болгож

байна. Мөн гэрлэлт, түүний утга учир, нөхөн үржихүй хийгээд аз жаргалтай айл гэрийг хэрхэн зохион байгуулах арга ухааныг зааж сургасан “Аз жаргалтай айл гэрийн амьдрахуйн ухаан” зохиолыг хүргэж байна.

84(1)-4

Г-93

ЭШФ Б-26979-26980



Гэндэндарам Ж. **Хорвоог харсан цонх**. - УБ.: Бэмби сан, 2017.- 382х. (Gems of wisdom Цуврал-16)

Зохиогчийн энэхүү бүтээлд сонин сэтгүүлд нийтлүүлж байсан 150 гаруй өгүүллэг, эссэ, нийтлэл, тэмдэглэл, шүүмжээс одоогоор ач холбогдлоо алдаагүй байгаа 40 гаруйг сонгон авчээ. Мөн Чингисийн их “Ясса хууль”, “Буддха багшийн сургаалын үндэс”, “Монгол” гэдэг үгийн учир зэрэг судалгааны бүтээл багтжээ.

84(1)

Г-93

ЭШФ Б-26981-26982



Гэндэндарам Ж. **Зүрхэн толтун шивнэл-1** / Хян. Ш.Сүрэнжав.- УБ.: Бэмби сан, 2017.- 318х. (Gems of wisdom Цуврал-17)

Ж.Гэндэндарамын ухаанаас урган соёолсон уламжлалаас гүн улбаатай сургаал-шүлгэн тарни бүхий эл номонд уламжлалт соёл сэтгэлгээний мөр тод дурайжээ. Энэхүү ном нь 7 бүлэгтэй бөгөөд бүлэг тус бүр нь өөр өөрийн гэсэн утга санааг гаргаж байгаагаараа онцлог талтай юм.

84(1)-5

Г-93

ЭШФ Б-26983-26984

Гэндэндарам Ж. **Амьдралын зам = Таны зурсан зураг, төрсөн төөрөг** / Хян. А.Эрдэнэ-Очир.- УБ.: Бэмби сан, 2017.- 340х. (Gems of wisdom Цуврал-18)

“Амьдралын зам” зохиолдоо хүний амьдралын сайн муу, баяр хөөр, уй гашууг уран зохиолын хэлбэрээр өгүүлэхийг хичээж үүнийгээ ардын зүйр цэцэн үг, сургаал айлдварыг ашиглан өөрийн санаагаа илэрхийлжээ. Таны зураг төөрөг нь гарын хээ, тооны ухаан болон одод гарагийн хоорондын харилцан нөлөөллийн үндсэн дээр тааварлан хэлэх ухааныг өгүүлнэ.

84(1)

Г-93

ЭШФ Б-26985-26986





Лхагва Ж. **Толгодын цаана ингэ буйлна**: Өгүүллэг, тууж, кино зохиол, эсээ, шүлэг, минатюр / Эмхт. Л.Нарандулам, Т.Идэр.- УБ.: Гэрэлт судар, 2017.- 803х.- ISBN 978-99978-0-370-2.

Зохиолч Жагдалын Лхагва нь 1991 онд энэхүү “Толгодын цаана ингэ буйлна” номоороо Монголын Зохиолчдын Эвлэлийн шагнал авч байжээ. Мөн энэ номдоо Монголын нэгэн үеийн алдартай зохиолчидтой уулзаж, тэдний яриа хөөрөөг сонсож байсны дотроос алиа хошин, эмгэнэлтэй, сургамжтайг нь түүвэрлэн авч эмхэтгэсэн байна.

84(1)

Л-87

/НУН унш-3ш/

ЭШФ Б-27056-27057

Дамбын Төрбатын уран бүтээлийн чуулган: Боть-1-8 / Санаачлагч. Л.Шүрэнцэцэг; Эмхт. Ж.Мөнхбат, Т.Оргил; Хян. М.Оюунсүрэн, Р.Оюунгоо, Э.Дэмбэрэлсүрэн.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.

Дамбын Төрбат нь Монголын говиос тодрон утга зохиолын өндөр босгыг алхаж орсон цагаасаа роман, жүжиг, дуурь, кино, яруу найргийн хур бэлтэй том зохиолчийн энд зэрэгцэж чадсан уран бүтээлч юм. Түүний туурвисан бүтээлийг 8 боть цувралаар танилцуулж байна.



84(1)

М-59

Б.1: Зүрхэн тарни: Шүлэг, яруу найраг.- 432х.- ISBN 978-99973-7-969-1.

ЭШФ Б-27114-27115

Б.2: Үлэмжийн чанар: Шүлэг, яруу найраг.- 584х.- ISBN 978-99973-7-968-3.

ЭШФ Б-27116-27117

Б.3: Хийморийн чуулган: Дурсамж.- 424х.- ISBN 978-99973-7-967-5.

ЭШФ Б-27118-27119

Б.4: Ирж яваа цаг: Кино зохиол.- 392х.- ISBN 978-99973-7-966-7.

ЭШФ Б-27120-27121

Б.5: Алт амилах цаг: Кино зохиол.- 528х.- ISBN 978-99973-7-965-9.

ЭШФ Б-27122-27123

Б.6: Амьдралын улаан шугам: Жүжгийн зохиолууд.- 480х.- ISBN 978-99973-7-970-5

ЭШФ Б-27124-27125

Б.7: Дурлал загварын ордон: Жүжгийн зохиолууд.- 640х.- ISBN 978-99973-7-972-1.

ЭШФ Б-27126-27127

Б.8: Гүн гэрийн гүнж: Жүжиг, дуурийн цомнол.- 528х.- ISBN 978-99973-7-971-3.

ЭШФ Б-27128-27129



Номинчимэд Б. **Аугаа эрин**: Түүхэн роман / Зөвлөсөн. Л.Мөнхтөр; Хян. Д.Оюунчимэг, Д.Сүрэнжаргал, О.Энхжавхлан.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 472х.- ISBN 978-99978-0-365-8.

Б.Номинчимэд нь “Аугаа эрин” түүхэн цуврал ном гаргаж байгаа бөгөөд энэхүү номонд Монголчууд хүчирхэгжин мандсан хийгээд уруудан доройтсоны учир шалтгааныг уран сайхнаар харуулжээ.

84(1)-44

Н-72

/НУН унш-3ш, ГНОФ-3ш/

ЭШФ Б-27094-27095

Оюунчимэг Д. **Тэнгэрийн цаг болоогүй**: Тууж, өгүүллэгийн түүвэр / Хян. Б.Номинчимэд.-УБ.: Соёмбо принтинг, 2017.-204х.- ISBN 978- 99929-93-67-5.


Энэхүү номонд “Тэнгэрийн цаг болоогүй”, “Буудлын эзэн”, “Үргэлжид холын хүн”, “Ус шиг цэнхэр зэрэглээ”, “Уулын нүд”, “Хайрын домог” гэсэн 6 тууж, өгүүллэг оржээ.

84(1)-44

О-63

/НУН унш-3/

Б-27170-27171



Сэсээр З. **Хувь заяаны орчил**: 6 боть цуврал роман / Хян. С.Пүрэв, С.Нарангэрэл, Л.Оросоо.- УБ.: Адмон принт, 2014.


Энэхүү "Хувь заяаны орчил" номын эхний 3 боть 2006 онд хэвлэгдэн уншигчдын гар дээр очиж байсан билээ. Энэ удаад "Хувь заяаны орчил" зургаан ботиор хэвлэгдэн гарч байна. Энэ номонд бараг 100 жилийн хүн, хүний нийгмийн амьдралд тохиолдож өнгөрсөн, тохиолдож буй үйл явдлууд гарна. Зохиогч "Сүрэн"-гээр зохиолынхоо гол дүрийг гаргасан бөгөөд энэ хүнээр, хүн ерөөс ямар амжилтанд хүрч болох хийгээд хэрхэн алдаж, онодог зэргийг гаргахын зэрэгцээ, тэр хүний нийгэмд эзлэх байр суурийг тодорхой харуулсан байна.

84(1)-44

С-97

- Б.1: Тал нутгийн хүү.- 368х.- ISBN 978-99973-0-316-5. ЭШФ Б-26993-26995
 Б.2: Амьдралын эхлэл.- 314х.- ISBN 978-99973-0-317-2. ЭШФ Б-26996-26998
 Б.3: Айдас нөмөрсөн өдрүүд.- 372х.- ISBN 978-99973-0-318-9 ЭШФ Б-26999-27001
 Б.4: Мөрдөлт.- 321х.- ISBN 978-99973-0-319-6. ЭШФ Б-27002-27004
 Б.5: Хоригдол.- 360х.- ISBN 978-99973-0-320-2. ЭШФ Б- 27005-27007
 Б.6: Амьдрал-тэмцэл.- 470х.- ISBN 978-99973-0-321-9. ЭШФ Б-27008-27010

Хэюүд боржигон овгийн Барнангийн Доржпалам (1951-1996): Хөрөг, ярилцлага, дурсамж.- УБ.: 2017.- 108х.



Энэхүү ном нь Дундговь аймгийн Говь-Угтаал нутгийн хүү гал цогтой, авьяаслаг найрагч Барнангийн Доржпаламын анд нөхөд, найрагч зохиолчдынх нь гэгээн халуун үг, гэрэлт яруу дурсамжаас бүтсэн бөгөөд түүний шүлэг, найраглал нь хөдөө нутаг, морь мал, хайр сэтгэл, түүх, эр цэргийн амьдрал, гүн ухаан гээд нэн баялаг билээ.

84(1)-5

Х-95

ЭШФ Б-27229-27230



Цэнджав Д. Цахарын хар шуурга: Шилмэл туужууд-1 / Зөвлөн тунгаасан Л.Түдэв.- УБ.: Хүннү пресс, 2017.- 314х.- ISBN 978-99978-868-8-0.

“Шинэ зууны шилдэг туужуудын цуврал” ботиудыг “Хүннү пресс” ХХК нь уншигчдын хүртээл болгож байгаа билээ. Эхний удаад шилдэг бүтээлийн “Алтан өд” наадмын хоёр удаагийн шагналт нэрт зохиолч Долгорын Цэнджавын туужуудыг “Цахарын хар шуурга”, “Гүн тайгын манан” гэсэн 2 дэвтэр болгон нийтэлж байна. Энэхүү номд “Цахарын хар шуурга”, “Хөх жавар”, “Өнцөгдсөн сэнтий” хэмээх туужууд оржээ.

84(1)-44

Ц-95

/НУН унш-3ш, ГНОФ-3ш/

ЭШФ Б-27073-27074

Цэнджав Д. Гүн тайгын манан: Шилмэл туужууд-2 / Зөвлөн тунгаасан Л.Түдэв.- УБ.: Хүннү пресс, 2017.- 308х.- ISBN 978-99978-868-7-3.



“Хүннү пресс” ХХК Монголын утга зохиол судлаач, шүүмжлэгч, мэргэжилтэн, уншигчдын санал дүгнэлтэд тулгуурлан “Шинэ зууны шилдэг туужуудын цуврал” ботиудыг олны хүртээл болгож байгаа юм. Долгорын Цэнджавын шилмэл туужуудыг “Цахарын хар шуурга”, “Гүн тайгын манан” гэсэн 2 цувралаар гаргасан билээ. Энэхүү 2-р цувралд “Гүн тайгын манан”, “Тэнгэрт хальсан тоос”, “Тал сар”, “Маргааш л дайн эхэлчих юм шиг 1080 хоног минь” хэмээх туужууд багтжээ.

84(1)-44

Ц-95

/НУН унш-3ш, ГНОФ-3ш/

ЭШФ Б-27066-27067



Цэнджав Д. Чонын алтан шагай: Роман / Ред. Ч.Наранцэцэг.- 3дахь хэвл.- УБ.: “BCI” хэвлэл, 2017.- 400х.- ISBN 978-99929-65-70-3.

Зохиолч, нийтлэлч, утга зохиол судлаач До. Цэнджавын "Чонын алтан шагай" роман хоёр дахь удаагаа хэвлэгдэн уншигч таны гар дээр очиж байна. Зохиолч энэ романыгаа гуравдугаар бүлгийг шинээр бичсэн ба уг

роман 2000 онд сүүлийн арван жилд гарсан шилдэг 10 романы дотор орж үнэлэгдэн тусгай шагнал хүртжээ. Тэрээр өнөөгийн орчин үеийн амьдралыг нүдэнд харагдаж, сэтгэлд буутал, энгийн оновчтой үг хэллэгээр илэрхийлсэн байна.

84(1)-44

Ц-95

/НУН унш-3ш, ГНОФ-3ш/

ЭШФ Б-27015-27016

Р.Чойном: 13 боть цуврал / Ботийн зөвлөлийн дарга. Д.Ганболд.- УБ.: Жиком пресс, 2017.

“Өд” сангаас эрхлэн Монгол улсын төрийн шагналт Ринчиний Чойномын бичсэн шүлэг, найраглал, тууж, роман, хүүрнэл зохиол, орчуулга, захидал болон түүний тухай дурсамж, хууч яриа, ярилцлага, судлал, шинжлэлийг багтаасан “Р.Чойном” зохиол бүтээлийн 13 ботийг та бүхэнд хүргэж байна.



84(1)

Ч-75

- Б.1: Шүлэг / Ботийг эрхл. Д.Ганболд.- 526х.- ISBN 978-99978-60-14-9.
/НУН унш-3ш/ ЭШФ Б-27021-27022
- Б.2: Шүлэг / Ботийг эрхл. Д.Ганболд.- 454х.- ISBN 978-99978-60-15-6.
/НУН унш-3ш/ ЭШФ Б-27023-27024
- Б.3: Найраглал / Ботийг эрхл. Л.Дашням.- 404х.- ISBN 978-99978-60-02-6.
/НУН унш-3ш/ ЭШФ Б-27025-27026
- Б.4: Найраглал / Ботийг эрхл. Л.Дашням.- 382х.- ISBN 978-99978-60-03-3.
/НУН унш-3ш/ ЭШФ Б-27027-27028
- Б.5: Шүлэглэсэн тууж, роман / Ботийг эрхл. Д.Цэдэв.- 382х.- ISBN 978-99978-60-16-3.
/НУН унш-3ш/ ЭШФ Б-27029-27030
- Б.6: Шүлэглэсэн тууж, роман / Ботийг эрхл. Д.Цэдэв.- 454х.- ISBN 978-99978-60-17-0.
/НУН унш-3ш/ ЭШФ Б-27031-27032
- Б.7: Хүүрнэл зохиол / Ботийг эрхл. С.Байгалсайхан.- 359х.- ISBN 978-99978-60-00-2.
/НУН унш-3ш/ ЭШФ Б-27033-27034
- Б.8: Хүүрнэл зохиол / Ботийг эрхл. С.Байгалсайхан.- 350х.- ISBN 978-99978-60-01-09.
/НУН унш-3ш/ ЭШФ Б-27035-27036
- Б.9: Орчуулга / Ботийг эрхл. Ж.Нэргүй.- 503х.- ISBN 978-99978-60-09-5.
/НУН унш-3ш/ ЭШФ Б-27037-27038
- Б.10: Захидал / Ботийг эрхл. О.Содномпил.- 358х.- ISBN 978-99978-60-18-7.
/НУН унш-3ш/ ЭШФ Б-27039-27040
- Б.11: Дурсамж-хууч яриа / Ботийг эрхл. А.Шартолгой.- 430х.- ISBN 978-99978-60-07-1.
/НУН унш-3ш/ ЭШФ Б-27041-27042
- Б.12: Сурвалжлага-ярилцлага / Ботийг эрхл. А.Шартолгой.- 382х.- ISBN 978-99978-60-08-8.
/НУН унш-3ш/ ЭШФ Б-27043-27044
- Б.13: Судлал, шинжлэл / Ботийг эрхл. Л.Нямаа.- 527х.- ISBN 978-99978-60-19-4.
/НУН унш-3ш/ ЭШФ Б-27045-27046

УРЛАГ СУДЛАЛ

Гантулга Д. **Монголчууд үлэмж ертөнцийн орон зайд** / Хян. С.Дулам.- УБ.: Голден Легион, 2017.- 172х.- ISBN 978-99978-0-324-5.

Энэхүү номд Монгол ардын дүрслэн чимэглэх урлагийн мөн чанарыг хүн төрлөхтний соёлын гарал үүсэл, түүхэн хөгжлийн үе шатуудын талаарх түүх, археологийн ухаан, угсаатны зүй хийгээд нүүдэлчдийн ертөнцийг үзэх үзэл болон аман соёлыг холбон судалж чимэглэх урлагийн утга илэрхийллийг тогтоохыг зорьжээ.

85.1(1)

Г-21

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Т-20492-20494

Төгсжаргал Ж. **Соноршуулга**.- УБ.: 2017.- 94х.- ISBN 978-99978-1-526-2.

Энэхүү номыг хөгжим сонирхон сонсогч, тоглогч, эхлэн суралцагч, хөгжмийн мэргэжлийн хэн бүхэнд зориулжээ. Мөн аялгууны сонсгол хөгжүүлэхэд чиглэгдсэн дасгалууд, хоолойн дасгал болон дуулах чадварыг хөгжүүлэх зорилгоор MP3-т бичиж оруулсан нь бие даан сонсголоо хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.




85.31

Т-56

/НУН унш-3ш/

ЭШФ Т-20538-20539



Театр шинжлэл: Утга зохиолын судлал шинжлэл: Цуврал-11 / Ред. Ж.Долгорсүрэн, Д.Батсайхан.- УБ.: Жиком пресс, 2017.- 158х.- ISBN 978-99978-0-636-9.

Урлаг, уран сайхны бүтээл туурвилын хөгжил хөдөлгөөнд судлал шинжлэл тэргүүлэх үүрэгтэй. Урлаг, утга зохиолын шүүмж, шүүмжлэл хэмээхээр уншигчид болон уран бүтээлчид таагүй утгаар хүлээж авдаг нь нууц биш. Энэ нь "шүүмжлэл" "шүүмжлэгч" гэсэн нэрнээс үүдэлтэй юм. Уран бүтээлийн ололтыг ч доголдлыг ч цэгнэж дүгнэж ярилцах нь бүтээл туурвил сайжрахын үүд хаалга, түлхэц болох ач холбогдолтой билээ. Энэ үүднээс СУИС-иас "Тайзны урлаг" шүүмж бичлэгийн улсын уралдааныг жил бүр зохион явуулж ирсэн бөгөөд 2015, 2016, 2017 оны эхний байрт шалгарсан бүтээлүүд энэхүү номонд орсон болно.

85.33


Т-34

/НУН унш-7ш, ГНОФ-5ш/

ЭШФ Б-24987-24989

ШАШИН СУДЛАЛ

Вээдавъяаса М. **Бхагавата-Гийта** / Орч. Ж.Гэндэндарам; Хян. Г.Мэнд-Ооёо.- УБ.: Бэмби сан, 2017.- 375х. (Gems of wisdom Цуврал-4)




“Бурханы Дээд Бодьгал” буюу Бхагавата-Гийта хэмээх энэхүү судар нь Бурханы Бурхан Кришна бээр өөрийн дотно анд чин бишрэлт Аржунад айлдсан зарлиг сургаал юм. Энэ ертөнцөд хүн болж төрсөн л бол түүнд биелүүлэх ёстой үүрэг байдаг. Тэр үүргээ биелүүлэхийн тулд ямар ч бэрхшээл саадыг туулж, тэр байтугай байлдаан тулалдаан хийж түүнийгээ биелүүлэх ёстой гэдгийг бурхан дээдэс сургаж байгааг энэ сударт өгүүлжээ.

86.3

В-97

ЭШФ Б-26957-26958



Датт С. **Буддхны шашны түүх** / Орч. Ж.Гэндэндарам; Хян. Ч.Дамбажав.- УБ.: Бэмби сан, 2017.- 348х. (Gems of wisdom Цуврал-9)


Өнөөгийн дэлхий ертөнцөд дөрвөн томоохон шашин ноёрхож байгаа нь Буддхизм, Хиндүизм, Лал, Загалийн шашин юм. Ер нь шашин гэдэг юу вэ гэдэг асуулт байнга тавигдаж өнөөг хүртэл үнэн хариугаа хүлээсээр байгаа билээ. Харин Шаакя удмын хүү Сиддхарат энэ асуудалд үнэн хариуг өгсөн боловч өнөөгийн Буддхист шашинтай зарим оронд тухайлбал Төвд, Монгол зэрэг оронд ч өөр үзэл бодлоор тайлбарлан шашин биш мухар сүжиг болгон хувиргажээ. Тиймээс Буддхын шашны үүсэл хөгжил, мөхлийг илтгэсэн энэхүү номоороо нэрт орчуулагч Ж.Гэндэндарам уншигч та бүхэнд шашны тухай зөв ойлголт өгөх, Буддхын шашин болон Шарын шашны хоорондын ялгааг ойлгуулахыг зорьжээ.

86.3

Д-38

ЭШФ Б-26967-26968

Дхармарагшид Б., Шаастри Ч. **Номын мөр: Дхармабада = Сэтгэлийн шүүлэг** / Орч.Ж.Гэндэндарам; Хян. С.Лхагважав.- УБ.: Бэмби сан, 2017.- 363х. (Gems of wisdom Цуврал-7)




Дхармабада нь Бурхан Буддхагийн гүн ухааны үнэлж баршгүй эрдэнэ бөгөөд Бурхан багшийн энэхүү сургаал нь Бурханы шашны үндсэн утга санааг илэрхийлж шашныг мөн чанараар нь ойлгоход туслах юм. Энэ сударт ертөнцийн үнэн, эрдэм ухааны хүч, оюун ухааны бясалгал, нярваан болох замыг бодитойгоор дүрслэн өгүүлсэн байна.

86.3

Д-80

ЭШФ Б-26963-26964



Убанишад: Залбирлын арван нэгэн шад / Орч.Ж.Гэндэндарам; Хян. Х.Зандраабайдий.- УБ.: Бэмби сан, 2017.- 397х. (Gems of wisdom Цуврал-1)

Энэхүү судар нь арван нэгэн Убанишадаас бүрдэх бөгөөд хорвоо ертөнц, түүн дээр буй болсон амьтай, амьгүй бодь юмс хэрхэн үүссэн болон энэ бүхний үүсэл төрөлд үнэн, бодит чанар гэж байх ёстой бөгөөд түүнийг Брахма гэж нэрлэж тэрхүү Брахмаг ойлгож мэдэхийн тулд хэрхэх тухай айлдваруудын хураангуй юм.

86.3

У-12

ЭШФ Б-26951-26952

Сүхээ Б. Ертөнцийн оршихуйн сургаал: Буддын гүн ухаан / Хян. Л.Ням.- УБ.: АЖМА принтинг, 2017.- 296х.- ISBN 978-99978-1-475-3.

Энэхүү бүтээл нь хүн төрөлхтөн болоод Монголчуудын сэтгэлгээнд орших буруу үзэл бодлыг арилган зөв үзэл, ёс зүйн хүмүүжлийг төлөвшүүлэхэд оршино. Буддын шашны гүн ухааныг судалж, бурхан шашны уламжлалт соёл болон түүний сургаалын мөн чанарыг ухаарснаар шүтэн барилдлагын онол, хоосон чанарын сургаалын учрыг тунгааж юмс үзэгдлийн оршихуйн зүй тогтол, буддын гүн ухааны танин мэдэхүйн онолын нэгээхэн хэсгийг ухаарах буйзаа.

86.35

С-86

/НУН унш-2ш/

ЭШФ Б-27064-27065



ГҮН УХААН



Свифт А. Улс төрийн философи / Орч. Б.Батчулуун; Хян. Ч.Өнөрбаяр.- 3дахь хэвл.- УБ.: Мөнхийн үсэг, 2014.- 262х.- ISBN 978-99962-64-52-8.

Энэхүү ном нь олон улсын зүй ёс, эрх чөлөө, тэгш ёс, эмэгтэйчүүдийн эрх, улс төрийн онолын арга зүйн асуудал зэрэг олон сэдвийг багтаажээ. Мөн улс төрийн философийг бодит амьдралд ойртуулж уншигчдад өнөөгийн улс төрийн ээдрээт байдлыг ойлгоход дөхөм болгосноороо судлаач, оюутнуудын гол хэрэглэгдэхүүн болох ач холбогдолтой юм.

87.3

С-40

ЭШФ Т-20570-20572

Даш-Ёндон Б. Нагаржунын гүн ухаан, ёс зүй: Шүтэн барилдахуйн онол / Ред. Г.Чулуунбаатар.- УБ.: Соёмбо принтинг, 2016.- 279х.- ISBN 978-99973-79-21-4.

Эртний Энэтхэгийн их сэтгэгч, соён гэгээрүүлэгч Нагаржунын онол сургаал мянга мянган жил хүмүүсийн оюун сэтгэхүйг баяжуулан



гэгээрүүлсээр иржээ. Нагаржунын шүтэн барилдахуйн буюу хоосон чанарын онол, сургаал, дундад үзэл гэж юуг хэлэх, буддын гүн ухаан шашин хоёр ялгаатай юу, Дорно, Өрнийн эртний их сэтгэгчдийн философи, ёс суртахууны сургаал өөр хоорондоо хэрхэн авцалддаг зэрэг бусад асуултад хариу хайхад уг ном чухал ач холбогдолтой юм.

87.3

Д-39

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Б-25021-25023

СЭТГЭЛ СУДЛАЛ



Фрейд З. **Андуу ташаа үйлдлүүд** / Орч. М.Баяртогтох.- УБ.: Битпресс, 2017.- 64х.- ISBN 978-99978-1-256-8.

Энэхүү судалгааны гол зүйл бол өвчин эмгэгтэй ер адилгүй атлаа эв эрүүл ямар ч хүмүүст олонтаа тохиолддог, өдгөөг хүртэл их анхаарч байгаагүй ч маш тодорхой тийм үзэгдлүүд юм. Үүнийг хүмүүсээс гардаг андуу ташаа үйлдлүүд / fehlleistungen/ гэдэг бөгөөд тухайлбал ямарваа нэг зүйл хэлэх гэснээ ташаарч нэг үгийг нь санамсаргүй сольчих, бичиж байсан юмныхаа

аль нэг үсэг, үгийг санаандгүй юм уу, санамсаргүйгээр мөн л гээчих, бичиг, ном зохиол уншиж байснаа өөр хий юм өөрөө ч мэдэлгүй уншаад явчих, уулаас өвчин хуучгүй атлаа хүний хэлсэн өгүүлсэн зүйлийг буруу дуулах зэргийг хамааруулж байгаа юм.

88.3

Ф-86

/НУН унш-5ш, ГНОФ-7ш/

ЭШФ Б-27070-27072

Канэман Д. **Тунгаан бодох уу, түргэн шийдэх үү?** / Орч. Б.Гэрлээ.- УБ.: НЭПКО., 2017.- 522х. ISBN 978-99978-51-11-6.


Сэтгэл судлаач Даниел Канэман “Тунгаан Бодох уу, Түргэн Шийдэх үү” хэмээх энэхүү бүтээлээрээ эдийн засгийн салбарт нобелийн шагнал хүртжээ. Уг бүтээлдээ тэрээр хүний сэтгэхүй, оюун бодлыг залж чиглүүлдэг хоёр системийн тухай дэлгэн өгүүлсэн байна. Судлаач маань ахуй амьдралын алив нөхцлөөр жишээлэн чухам хэдийд зөн совиндоо итгэж, хэдийд сайтар тунгааж бодох ёстойг дэлгэрэнгүй тайлбарлажээ.

88.6

К-19

/НУН унш-4ш, ГНОФ-3ш, БС-5ш/

ЭШФ Б-25000-25002



Сургаал болон сургамжтай үгсийн цоморлогоос... / Эмхт. Б.Бадамсүрэн.- УБ.: Адмон принтинг, 2015.- 134х.- ISBN 978-99973-0-736-1.

Үсэг бичиг бий болоогүй байсан эрт дээр үеэс эдүгээ хүртэл хүн төрөлхтөн сургаал үгс болон сургамжтай үгсийг зохиож хүүхэд залуучуудыг амьдралын замд орох, хүн болгон хүмүүжүүлэхэд хэрэгсэл болгон ирсэн түүхтэй. Энэ номд бурхан багшийн сургаалаас эхлээд ардын сурган

хүмүүжүүлэх арга ухааны 10 зарчим, Монголчуудын гэрийн хүмүүжлийн уламжлалт сургаал, Монголын нэрт хүмүүсийн хэлсэн сургаал үг, бусад улс үндэстний эрдэмтэн, мэргэдийн хэлсэн сургаамжит үгс оржээ.

94.8

C-75

ЭШФ Б-27050-27052

ГАДААД ХЭЛ ДЭЭРХ НОМ

Цэрэнсодном Д. **Истоки и своеобразие письменной поэзии Монголов эпохи средневековья** / Отв. ред. Т.М.Дугаржапова.- УБ.: Тод бичиг, 2017.- 220с.- ISBN 978-99978-1-438-8.




Монголы имеют древние традиции поэтического творчества. Об этом свидетельствуют эпические поэмы "Гэсэр", "Джангар", "Хан Харангуй", вставные стихи "Сокровенного сказания", состоящие из многих тысяч строк. Отметим, что в фольклоре древних монгольских кочевых племен песня и стихи играли важную роль. Это вставные стихи из "Двенадцати деяний Будды" Чойджи-Одсэра, колофон из Панчараки, переведенный также Чойджи-Одсэром в 1308 году, стихи из книги о китайско-монгольских отношениях, переведенные Эсэнбухой, стихи, написанные квадратным письмом Пагбы на воротах дворца "Чу-Юн-Куань" в 1345г.

83.3(1)

Ц-96

/НУН унш-3ш/

ЭШФ С-88501-88502



Urgamal M., Oyuntsetseg B. **Atlas of the endemic vascular plants of Mongolia** / Edited by. V.Gundegmaa. M.Urgamal.- UB.: Bembi San, 2017.- 108p.- ISBN 978-99978-1-307-7.


The atlas of the Endemic Vascular Plants of Mongolia is the first atlas of the Mongolia flora ever. This book contains taxonomy, distribution, lifeform, habitat, typus and other information of a total of 120 species (included 12 subspecies) are endemic vascular plants (3.83%) belonging to 49 genera and 19 families of Mongolia updated and is presented.

28.59(1)

U-73

ГФ-18818-18825

Li Wu., Wenli Rong. **Contemporary China's economy**.- China.: China intercontinental Press, 2014.- 271p.- ISBN 978-7-5085-2783-3.




The reform in China is not only reform of economic system, and it also include the reform of political system. Just as Deng Xiaoping said, the reform of economic system cannot succeed without the guarantee of reform of political

system. China is a big country with a population of 1.3 billion, so the reform of political system must be implemented under proper leadership step by step. Without a firm and steady leader and set steps, it would certainly lead to a chaotic "pseudo-democracy". This kind of "democracy" cannot guarantee the true rights and interests of the Chinese people, nor help the sustainable development of the Chinese economy. Emphasizing the role of the government does not mean negating or underestimating the market. On contrary, the basic role of the market is getting strengthened with the continual progress of the market-oriented reform.

65.9(5Chi)

L-66

ОУХНУС 2511-2514



Qingmin Z. **Contemporary China's diplomacy**. - China.: China intercontinental Press, 2014.- 217p.- ISBN 978-7-5085-2793-2.


After the September 11 event, the calling for international cooperation on the war against terrorism became very strong. In order to get out of their predicament, the "East Turkistan" forces once again raised the banner of "human rights," "freedom of religion" and "interests of ethnic minorities," and have fabricated claims that "the Chinese government is using every opportunity to oppress ethnic minorities." This is done to mislead the public and deceive world opinion in order to escape blows dealt by the international struggle against terrorism. At the same time, they have constantly conspired for various terrorist incidents jeopardizing regional peace and stability, and thus have become the target of the "Shanghai Five" and "Shanghai Cooperation Organization" for regional stability.

66.4(5Chi)

Q-11

ОУХНУС 2519-2522

Wen L. **Contemporary China's society**. - China.: China intercontinental Press, 2014.- 274p.- ISBN 978-7-5085-2794-9.




Following several years' harvests, since 1985, the comparative profit of grain production began to decline. Under such circumstance, many farmers chose to plant commercial crops with higher economic effectiveness or deal in animal breeding, transportation or small business. Some people chose to work in urban areas outside their hometowns. Since there are more people and less land, which is divided into small pieces, and there is not an integrated social security system in rural areas, rural families engaged in by-business began to make less effort in farming, only expecting to have enough grain for the daily life of their families.

60(5Chi)

W-50

ОУХНУС 2507-2510



Lequn W., Jian Ch. **Contemporary China's politics**. - China.: China intercontinental Press, 2014.- 247p.- ISBN 978-7-5085-2791-8.

The contemporary political of China is originated from the political system established during the revolutionary war period. It is integrated with the great achievements of the world political civilization and deeply rooted in the Chinese conditions, with obvious Chinese characteristics. The CPC has been adhering to realizing the goal for the democracy of majority and set as one of its targets to

rejuvenation of the Chinese nation.

66.3(5Chi)

L-50

ОУХНУС 2515-2518

Jinping Xi. **The governance of China**. - China.: Foreign Languages Press, 2014.- 515p.- ISBN 978-7-119-09023-8.



XI JINPING
THE GOVERNANCE OF CHINA

After the 18th National Congress of the Communist Party of China (CPC) in 2012, the new CPC Central Committee, with Xi Jinping as the general secretary, set off on a new journey of reform and opening up and modernization. In the course of this new start, Xi Jinping has made a series of speeches on the governance of China. Representing the concepts and principles of governance of the CPC leadership, his new ideas and assessments have answered both theoretical and practical questions about China's development in this new phase of the country's history. «Xi Jinping: The Governance of China » is a compilation of Xi Jinping's major works from November 15, 2012 to June 13, 2014; it comprises 79 speeches, talks, interviews, instructions and correspondence in 18 chapters.

66.3(5Chi)

J-52

ОУХНУС 2523-2526